



МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2017.06.28, ЛИХАГВА ~ №122 (668)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ерөнхийлөгч "Ард түмэн улс орныхоо эзэн гэдгээ дахин нотоллоо" хэмээн онцоллоо.

Гаднын ажиглагчид сонгууль зохион байгуулалт сайтай байсан гэж дүгнэв.

Хоёр дахь шатны санал хураалтад 7.2 тэрбум төгрөг зарцуулахаар тооцжээ.

Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгч долдугаар сарын 10-нд тодорно.

Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль ирэх сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ.

ЭДИЙН ЗАСАГ

Хугацаа хэтэрсэн ипотекийн зээлийн 2.6 хувийг гадаад валютын зээл эзэлж байна.

"Хөвсгөл алтан дуулга"

компанийн хувьцаа хамгийн өндөр буюу 14.99 хувиар өсөв.

Улсын хэмжээнд геологийн судалгааны 40 төсөл хэрэгжиж байна.

"Алт-2" хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 33-59 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлнэ.

"Rio Tinto" Австрали дахь "Coal & Allied" нэгжээ БНХАУ-ын "Yancoal"-д худалдахаар болов.

НИЙГЭМ

С.Ганбаатарын хандив авсан хэргийг шүүх цагдаагийн байгууллагад дахин буцаажээ.

Сонгинохайрхан дүүрэгт шүлхий өвчин гарсан тул хорио цээрийн дэглэмийг чангатгав.

Гуравдугаар хорооллын эцсээс Гэмтлийн эмнэлгийн уулзвар хүртэлх замыг нээлээ.

Хөвсгөлийн Идэрийн голд 700 сая төгрөгөөр зөвхөндөг хөвдөг гүүр барив.

Он гарсаар 38 удаа усны осол гарч, 44 хүн амиа алдсаны 10 нь хүүхэд байжээ.

ДЭЛХИЙ

НАТО "Оросын түрэмгий санаархалд итгэлтэй"

байгаагаа мэдэгдсэн байна.

Бразилийн Ерөнхийлөгчийг таван сая ам.долларын хахууль авсанд буруутгажээ.

АНУ Сирийн тал химийн зэвсэг ашиглавал ноцтой хариу өгөхөө анхаарууллаа.

Д.Трампын Оростой холбоотой мэдээллийн улмаас CNN-ийн гурван сэтгүүлч халагдав.

Монгол дахь Хятадын аюулын онол нь шинэ зүйл биш гэж Global times-д бичжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
2017.06.28

33° | 18°
ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭЭНИЙГ МЭДЭЭЛЛИЙГ
8 ДУГААР НУУРГУУС ҮНШИНЭ УУ.

8 658 000 1029112 | 00668

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Солонгоруулах цаг



Хэрэв Монголыг чиглэх мөнгөний урсгалыг тогтвортой хөгжлийнхөө суурь болгоход зарцуулахгүй бол сүүлийн хоёр жилийн хугацаанд үүссэн хүндрэл хэдэн жилийн дараа ахиад л давтагдах эрсдэлтэй. ▶3

С.Батсайхан / ЗГМӨ

ЭДИЙН ЗАСАГ

Тавантолгойд буй төр, хувийн хэвшлийн ялгаа


Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

"Оюутолгой" компани цахилгааны төлбөрт жил бүр 160-200 тэрбум төгрөг өмнөд хөршид төлж байгаа. Хэрэв Тавантолгойн нүүрсний ордыг түшиглэн барихаар төлөвлөсөн 450 МВт хүчин чадалтай цахилгаан станцаа манай улс өдийд ашиглалтад оруулчихсан бол дээрх хэмжээний мөнгө дотоодын эдийн засагт үлдэх байлаа. Өмнийн говьд ажлын байр шинээр нэмэгдэж, тэр хэрээр олон хүний амьжиргаа дээшлэх байсан. Төвийн бүсийн болон өмнийн говийн стратегийн орд газруудын эрчим хүчний хэрэгцээг хангах үүрэг хүлээсэн Тавантолгойн цахилгаан станцаас "Оюутолгой"-г эрчим хүчээр хангах юм. Гэвч уг цахилгаан станц төслийн нэгжээс цааш хэтэрсэнгүй. Мега төслийн бэлтгэл ажил ийнхүү саатаар энэ оны хоёрдугаар хагастай золголоо.

"Эрдэнэс Тавантолгой"-н үйл ажиллагаа явуулж буй Тавантолгойн ордын дэргэд нэг тэрбум ам.долларын өртөгтэй цахилгаан станц барих санаачилга бол эртнийх. Худалдан авагч нь тодорхой болчихсон цахилгаан станцын төсөл хөрөнгө оруулалтаа богино хугацаанд нөхөх боломжтой гэдэг.

▶11

ЗГМ: ИНФОГРАФИК



УЛС ТӨР

МАХН сонгуулийн хувь заяаг шийднэ

Эдийн засгийн хувьд 22.1 тэрбум төгрөгийн алдагдал хүлээнэ

Б.Даваатогтох
@datoZGM

Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн санал хураалт түүхэнд анх удаа дахин санал хураалтаар үргэлжлэхээр болсныг Сонгуулийн ерөнхий хороо албан ёсоор мэдэгдлээ. Хилийн чанад дахь, Ерөнхийлөгчийн сонгуульд саналаа өгөхөөр бүртгүүлсэн 7209 иргэн ирэх сарын 4-нд Монгол Улсын дипломат

төлөөлөгчийн газар байрладаг 33 улс дахь 45 салбар комиссын тогтоосон санал авах байранд очиж, дахин санал хураалтад оролцохоор болж байна. Харин сонгогчийн нэрсийн жагсаалтад бүртгэлтэй 1.9 сая орчим сонгогч ирэх сарын 9-нд улс орон даяар дахин "сонгуульдах"-аар боллоо. Төсвийн хөрөнгөөс 7.2 тэрбум төгрөг зарцуулах дахин санал хураалтад сонгуулиар хамгийн олон санал авсан, Ардчилсан намаас нэр дэвшигч Х.Баттулга болон МАН-ын нэр дэвшигч М.Энхболд нар өрсөлдөнө. Сонгуулийн саналын хуудаст дээрх хоёр нэр дэвшигчийн нэрийг бичих бөгөөд дахин санал хураалт болох хүртэл сонгуулийн сурталчилгаа хийхгүй юм.

▶2



Энэтхэгийн татварын шинэчлэлийн өмнөх сандрал

Киран Стейси

Энэтхэгт татварын шинэ журам хэрэгжиж эхлэхээс хэдхэн хоногийг өмнө бизнесийнхэн эмх замбараагүй байдал үүсэх эрсдэл байгааг анхаарууллаа. Энэ бямба гарагт хүчин төгөлдөр болох бараа үйлчилгээний нэгдсэн татварын хууль асар олон зөрчил, үл ойлголцлыг агуулж байгааг мэрэгжилтнүүд шүүмжилж байна. 2014 онд засгийн эрхэнд гарсан Ерөнхий сайд Нарендра Моди уг шинэчлэлийг мөрийн хөтөлбөрийнхөө гол зүйл болгосон. Эдийн засагчдийн үзэж буйгаар зөв хэрэгжвэл уг хууль

эдийн засгийн өсөлтийн хоёр хувийг хангах ба буруу замаар явбал ноён Модийн нэр хүндийг унагах эрсдэлтэй.

Энэтхэгийн үйлдвэрлэгчдийн холбоо саад бэрхшээлийг цэгцлэж дуусахаас наана хуулийг тур царцаахыг уриалсан анхны томоохон байгууллага боллоо. Засгийн газар сүүлийн гурван сард бодлогын нарийн заалтуудыг хэлэлцсэн боловч үндсэн зарчмууд дээр оддог хүртэл тохирч чадсангүй.


▶9

| | | | | | | | |
|----------------------------------|--------------------------------|--------------------------------|---|---|-----------------------------|-----------------------|-----------------------|
| MSE ALL 831.6 0.16% | АЛТ 1250.26 0.45% | ЗЭС 5794.50 0.10% | 10-ЧИНГИС БОНД 94.870 0.3% | 5-ЧИНГИС БОНД 99.920 0.09% | АМ.ДОЛЛАР 2353.38 | ЮАНЬ 344.65 | РУБЛЬ 39.85 |
|----------------------------------|--------------------------------|--------------------------------|---|---|-----------------------------|-----------------------|-----------------------|

Улс төр

СОНГОЛТ-2017

МАХН сонгуулийн хувь заяаг шийднэ



МАХН дээр гарч байгаа нэг том өөрчлөлт бол долдугаар сарын 1-нээс Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлнэ. Ингэснээр тус намын дарга Н.Энхбаярын ялтайд тооцох хугацаа дуусгавар болно.

ЭШЛЭЛ



“Сонгууль хүнд боллоо. Үүнийг харж, сонсож, мэдэрлээ. Гэхдээ өрсөлдөгчөөсөө илт давуу ялалт байгуулсан. 110 мянган сонгогчийн санал бол үнэмлэхүй ялалт байгуулсны илрэл. Гэвч олонхын санал авч илт давуу ялалт байгуулсан гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой байсан ч Сонгуулийн тухай хуулийн хатуу заалтыг баримталж дахин санал хураалт явуулахаар болж байна. Үндэсний их баяр наадам, сонгууль хоёрыг зэрэг хийнэ гэдэг бол ирц хүргэхгүй гэсэн башир арга. Сонгуулийн ерөнхий хороо эрх баригчдад үйлчилж байна. Ямар ч байсан бидэнд итгэж байгаа монголчуудынхаа итгэлийг алдахгүй.”

АН-ын нэр дэвшсэн Х.Баттулга



“Сонгуулийн эцсийн дүн гараагүй байна. Цаашид ямар ч харуу гарсан Монгол Улсынхаа нийгэм, эдийн засгийн төлөө ажилласаар байх болно гэдгээ хэлмээр байна. Сонгууль эхлэх үед би хоёр нэр дэвшигчдээ алд цэнхэр хадаг барин шударга өрсөлдөхийг хүссэн. Олон түмнээ хүндэлсэн, төрөө дээдэлж сонгууль явууля гэсэн уриалга гаргасан. Харамсалтай нь, сонгуулийн сурталчилгааны өдрүүдэд миний уриалга биелсэнгүй. Энэ сонгууль гутаан доромжилсон, эвлүүлэг хэрээс хэтэрсэн, иргэдийн элдэв бусын зүйлд уриалан дуудсан, тэрбум, тэрбумаар нь орон нутаг руу мөнгө зөөсөн, гадааас сая саяар нь хандив авсан сонгууль болж өндөрлөж байна. Миний санал гэнэт өссөн шалтгаанд эргэлзэж байвал Сонгуулийн ерөнхий хороог шалгуулж болно. Бид ч энэ асуудалд хамт ажиллахад бэлэн байна. СЕХ-ноос тогтоосон хугацаанд саналаа өгөөд баяр наадмаа тэмдэглэх нь зүйтэй болов уу.”

МАН-ын нэр дэвшсэн М.Энхболд



“Сонгуулийн ерөнхий хорооны мэдээллийг сонслоо. Санал нийлэхгүй байгаагаа мэдэгдэж байна. МАХН-ын олон мянган гишүүн шударга ёсны төлөө тэмцсэн. Мөн иргэний нийгмийн байгууллага олон жил тэмцсэн. Монголын ард түмэн өнөөдөр хулгайчгүй төртэй байх ёстой. Сонгуулийн ерөнхий хороо бол луйварчдын гар хөл болж, илбэчин байгууллага болжээ. Тэд хоёр өдрийн дотор 35 мянган иргэн шинээр бий болгосон. Бид ардчиллаа аврахын төлөө энэ хууль бус зүйлтэй эвлэрч чадахгүй. Бид үндсэндээ ялсан. Бид хамгийн цэвэр өрсөлдсөн. Монголын ард түмэн анхааруулга өгсөн сонгууль боллоо.”

МАХН-ын нэр дэвшсэн С.Ганбаатар

20 гаруй тэрбум төгрөг салхинд хийсгэхгүйн тулд иргэд идэвхтэй оролцох шаардлагатай

Энэ удаад сонгогчийн нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн бүх иргэн оролцоно гэдгийг тодотгоё. Өөрөөр хэлбэл, улс төрийн ууган хүчин болох МАН, удаах хүчин болох АН-ын нэр дэвшигчид гарааны “зурхай”-аас зэрэг хөдөлнө.

Онцлоход, дахин санал хураалтын ирц 50 хувьдаа хүрэхгүй бол Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг хүчингүй болгож, дахин сонгууль явуулах хуулийн заалттай. Мөн дахин санал хураалтаар хэн нэгэн нэр дэвшигч олонхын санал аваагүй тохиолдолд санал хураалт хүчингүй болох эрсдэл ч бий. Өөрөөр хэлбэл, сонгогчдын идэвх, оролцоо

болон нэр дэвшигчдийн ард түмнээ цуглуулах “оноо”-ноос дахин сонгууль явуулах, эсэх нь хамаарч байгаа. Хэрэв дахин санал хураалт хүчингүй болбол УИХ-аас дахин сонгуулийн товыг зарлах тухай хуульчилсан байдаг. Үнэхээр ийм нөхцөл байдалд хүрвэл зөвхөн эдийн засгийн хувьд 22.1 тэрбум төгрөгийн алдагдал хүлээнэ. Татвар төлөгчдийн халааснаас гарах энэ мөнгө зүгээр л салхинд хийсэн гэсэн үг. Мөнгөөр үл хэмжиж болох алдагдал ч бий.

С.Ганбаатар дахин санал хураалтад хэнийг дэмжих вэ гэдэг нь анхаарал татаж байна

Дахин санал хураалт улс төрийн гол хоёр тоглогч болох АН, МАН-ын дунд өрнөх нь нэгэнт тодорхой боллоо. Гэхдээ

хүлээлтээс давсан үр дүн үзүүлсэн МАХН-ын улс төрийн сонголт дахин санал хураалтын үр дүнд голлох нөлөө үзүүлнэ гэдгийг судлаачид онцолж байна. Тодруулбал, нийт сонгогчийн 30.19 хувь буюу 409899 иргэний саналыг авсан, МАХН-аас нэр дэвшсэн С.Ганбаатар дахин санал хураалтад аль нэр дэвшигчийг дэмжих вэ гэдэг нь олны анхаарлыг татаж байна. Энэ талаар улс төр судлаач Ү.Амарбат “МАХН сонгуулийн дүнг хэрхэн хүлээн авахаас бүх зүйл шалтгаална. Тус намаас нэр дэвшсэн С.Ганбаатар өөрийг нь дэмжсэн 400 мянга гаруй сонгогч руу хандаж ямар мессеж өгөх нь чухал. Мөн МАХН дээр гарч байгаа нэг том өөрчлөлт бол долдугаар сарын 1-нээс Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлнэ. Ингэснээр тус намын дарга Н.Энхбаярын ялтайд тооцох хугацаа дуусгавар болно. Тэгэхээр дахин санал хураалтын ирц хүрэхгүй бол дараагийн сонгуульд Н.Энхбаяр нэр дэвших эрхтэй болно. Үүнийг МАХН хэрхэн үнэлэх, ямар алхам

хийхээс их зүйл шалтгаална. Тэгэхээр гурван нэр дэвшигчээс илүү нам доторх хэсгүүдийн хөдөлгөөн дараагийн шатны санал хураалтад нөлөөлж чадна. Иргэдийн хувьд сонгуулиас залхсан шинжтэй байна” хэмээн байр сууриа илэрхийлжээ.

» Улс төрийн ууган хүчин болох МАН, удаах хүчин болох АН-ын нэр дэвшигчид гарааны “зурхай”-аас зэрэг хөдөлнө.

» Эдийн засгийн хувьд 22.1 тэрбум төгрөгийн алдагдал хүлээнэ.

» Хүлээлтээс давсан үр дүн үзүүлсэн МАХН-ын улс төрийн сонголт дахин санал хураалтын үр дүнд голлох нөлөө үзүүлнэ

Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн саатсан талаар Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн тайлбар хийсэн юм. Тэрбээр “Сонгуулийн хэсгийн хорооны хамгийн сүүлийн мэдээ мягмар гарагийн өглөөний 09.10 цагт ирсэн. Говь-Алтай аймгийн Цогт сумын 428 дахь хэсгийн хороо мэдээгээ дамжуулж чадахгүй саатсан. Үүнийг манай байгууллагын Мэдээлэл технологийн шуурхай баг болон Тагнуулын ерөнхий газраас шалгахад кабелийн сүлжээг нь тасалсан байсныг тогтоосон. Өөрөөр хэлбэл, хорлон сүйтгэх ажиллагаа явагдсан байна. Үүнийг хуулийн байгууллага шалгаж байна” хэмээн байр сууриа илэрхийлжээ.

Монгол Улсын эдийн засгийн байдал тийм сайнгүй байгаа энэ үед улсын төсвөөс 20 гаруй тэрбум төгрөг зүгээр салхинд хийсгэхгүйн тулд иргэд ирээдүйдээ эзэн болж, иргэний үүргээ биелүүлж, дахин санал хураалтад идэвхтэй оролцох зайлшгүй шаардлага тулгарч байгааг дахин санууллаар байна. [ЗГМ]

Б.Ганбаяр / ЗГМӨ

БАЙР СУУРЬ

Сонгуулийн сурталчилгаа сонгогчдын урмыг хугалсан

16 орны 22 төлөөлөгч таван долоо хоногийн хугацаанд Монгол Улсад ажиллаж байна



Б.Ганбаяр / ЗГМӨ

Б.Тогтох
ЗГМ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг ажигласан гадаадын ажиглагчид сонгуулийн урьдчилсан дүгнэлтийн талаар мэдээлэл хийлээ. Тэд Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн санал хураалт өрсөлдөөнтэй, эмх журамтай, зохион байгуулалт сайтай болсон хэмээн дүгнэжээ. Ээлжит сонгуулийг ажиглахаар ЕАБХАБ-ын гишүүн 16 орны 22 төлөөлөгч таван долоо хоногийн хугацаанд Монгол Улсад ажиллаж байна. Ажиглагчид нь энэхүү сонгууль хуулийн дагуу, ардчилсан зарчмаар явагдаж чадаж байгаа, эсэхэд дүгнэлт хийх зорилготой

байсан гэдгийг ЕАБХАБ-ын Парламентын ассемблейн төлөөлөгчдийн тэргүүн Ёориос Ваременос мэдээллийн эхэнд онцоллоо. Мөн тэрбээр сонгуулийг ажиглагчид өндөр сэтгэгдэлтэй байсныг дурьдсан юм. Харин зарим хэсгийн хороонд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал өгөх орчин, нөхцөлийг бүрдүүлж чадаагүй байсныг шүүмжлэв.

ЕАБХАБ-ын Сонгууль ажиглах хорооны тэргүүн, Элчин сайд Гээрт-Хинрич Арэнс “Миний бодлоор цөөн тооны

алдаа дутагдал байсан ч, Монгол Улсын иргэд Ерөнхийлөгчийн сонгуулийн эхний шатанд жинхэнэ ардчилсан сонголттой байлаа” хэмээн байр сууриа илэрхийлэв. Харин ЕАБХАБ-ын Тусгай зохицуулагч, богино хугацааны ажиглагчдын багийн удирдагч Гилиелмо Пики “СЕХ сонгуулийн бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу сайн зохион байгуулсан. Гэхдээ шүүх дээр нэр дэвшигчидтэй холбоотой хэргүүдийг шалгаж байгаа тул иргэдэд сонголттой хийхэд

ихээхэн эргэлзээ төрүүлж байлаа. Нэр дэвшигч хуулийн дагуу ялалт байгуулж, албан тушаалаа авсан гэсэн итгэлийг сонгогчдод төрүүлэх ёстой байсан юм. Улстөрч хүний хувьд хэлэхэд, энэ бол хамгийн том асуудал гэж харагдлаа. Гэсэн хэдий ч сонгууль нээлттэй боллоо. Удаахгүй хоёрдугаар шатны санал хураалт болно. Тиймээс энэхүү санал хураалтыг амжилттай зохион байгуулахад олон нийт эрх бүхий байгууллагуудтайгаа хамтран ажиллана гэдэгт итгэж байна” гэлээ.

Европын парламентын төлөөлөгчдийн тэргүүн Лайма Андрикиене “Сонгуулийн сурталчилгаа нь сонгогчдын урмыг хугаллаа. Ялангуяа залуучууд саналаа өгөхдөө хойрго хандсан. Нэр дэвшүүлэх талаар тавьсан хуулийн хоригууд нь жирийн сонгогчийг энэ сонгуульд идэвхтэй оролцоход тус болсонгүй” гэлээ.

Энэ үеэр тэд цагдаагийн байгууллагад сонгуулийн өдөр 150 орчим өргөдөл гомдол ирсний 86 нь санал худалдаж авсан тухай байсан талаар онцоллоо. [ЗГМ]

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонин мэдээ, нийтлэл, сурвалжлагатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» OPED@ZASAG.CO

Утас: 99901526 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

Нийтлэлчийн булан

Солонгоруулах цаг

ОУВС-гийн зургаа дахь хөтөлбөрөө эрчимжүүлэх ээдрээтэй зорилт биднийг хүлээж байна

Г.Байгал
@baigalZGM

Нар төөнөсөн зуны өдрүүдийг сонгууль тойрсон дуулиан, шуугиан улам ч халуун болгосоор. Уур амьсгал, улс төрийн халуурал газар авсан энэ үед Монгол Улс эвхрэх, эсэхээ шийдэх эргэлтийн цэг дээр зогсож байна. Тавдахь Ерөнхийлөгчөө сонгох амаргүй шийдвэртэй зэрэгцээд зургаадахь хөтөлбөрөө эрчимжүүлэх ээдрээтэй зорилт биднийг хүлээж байна. Ирэх 3-4 жил, цаашлаад эх орны хэтийн хөгжлийг энэ зун тодорхойлно. Учир нь гар барьж, толгой дохиод удаагүй ОУВС-гийн хөтөлбөр хэзээ мөдгүй эрчээ авахаар хүлээж буй. Нэг завин дээр суусан Монгол Улс, ОУВС гэх “хос” хоёр Монголын эдийн засгийг хэрхэн залуурдах бол. Угтаа тэд шинэ танилуд биш. Сүүлийн 20-иод жил хамтарч буй хуучин нөхөд. Зах зээлийн салхи сэвэлзж эхэлсэн гэртээ 1991 оны хоёрдугаар сард Монгол Улс дэлхийн 181 орныг эгнээндээ нэгтгэсэн ОУВС-гийн гишүүнээр элсэж байв. Ингэж л бид шинэ цагийн эдийн засгийн холбоотонтойгоо анх танилцсан түүхтэй.

Манай тал л эдийн засгаа элгээр нь хэвтүүлж, төрийн дансаа улаалгах бүртгээ Вашингтонд төвтэй Олон улсын валютын санг зорьсоор ирсэн. Бүр модоо бариад эхлэх бүртгээ аврал эрдэг болсон гэхэд хилсдэхгүй. Ингээд үзэхээр өнгөрсөн 30 орчим жилийн хугацаанд Монгол Улс ийм хүнд үетэй багаар бодоход таван удаа нүүр тулжээ. Нөгөө талаас хэдхэн жилийн дотор Монголын эдийн засаг хэдэнтэй унаж, боссон байх юм. Энэ хэлбэлзэл нь манай эдийн засаг төдий хэмжээний савлагаатай байгааг харуулна.

Ер нь Монголын эдийн засаг түүхий эдийн ханш даган дарцаг шиг хийсээд удаж байна. Ялангуяа, сүүлийн 15 жилд эдийн засгийн хэлбэлзэл улам гаарч, маш өндрөөс огцом унах болсон. Нэгэн цагт эдийн засгийн өсөлтөөрөө дэлхийд дээгүүрт бичигдэж байсан Монгол Улс хэдхэн жилийн дотор ёроолын цэгт хүрч, газардлаа. Нэг зах зээлээс хараат байх (Хятад), эдийн засгийн тулах цэг нь түүхий эдийн ханш байхын зовлонг бид ханатлаа амсаж байна. Нүүрс, зэс, төмрийн хүдэр гэсэн гарын арван хуруунд багтах хэдхэн түүхий эд бүхэл бүтэн Монголын эдийн засгийг тодорхойлж буй.

Тэгвэл хэзээ болтол бид ханшийн шуурганд хамхуул аятай хийсэх вэ. Үнийн салхинаас хорогдох арга байхгүй юм гэж үү. Угтаа дэлхийн зах зээлд үнэ, ханш байнга л хэлбэлзэж байдаг. Гагцхүү тэр үнийн шуургыг тогтоож, торгоож чадах эдийн засгийн бат суурийг босгож чадвал ханшийн уналтад зөөлөн газардах боломж бий. Энэ нь зөвхөн ганц бус солонго

| ХӨТӨЛБӨР | ЭХЭЛСЭН ОГНОО | ДУУССАН ОГНОО | НИЙТ ЗЭЭЛ (МЯНГАН \$) | АШИГЛАСАН (МЯНГАН \$) | АШИГЛАЛТ (ХУВЬ) |
|---|---------------|---------------|-----------------------|-----------------------|-----------------|
| Стэнд-Бай хөтөлбөр (SBA) | 2009.04.01 | 2010.10.01 | 153,300 | 122,640 | 80 |
| Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр (ECF) | 2001.09.28 | 2005.07.31 | 28,490 | 12,210 | 42.9 |
| Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр (ECF) | 1997.07.30 | 2000.07.29 | 33,390 | 17,437 | 52.2 |
| Өргөтгөсөн зээлийн хөтөлбөр (ECF) | 1993.06.25 | 1996.06.24 | 40,810 | 29,680 | 72.7 |
| Стэнд-Бай хөтөлбөр (SBA) | 1991.10.04 | 1992.12.31 | 22,500 | 13,750 | 61.1 |
| НИЙТ | | | 278,490 | 195,717 | 70.3 |

ОУВС-гийн Санхүүгийн газар ©

өсөлтөөр дэлхийд дээд амжилт тогтоох гэж байна. Энэ оны эхний гурван сард тус улсын ДНБ 0.3 хувиар өссөнөөр 103 улирал дараалан хямралын шинж тэмдэг илрээгүй эдийн засаг болоод байгаа ажээ. Хэдийгээр энэ улс ДНБ-ий хэмжээгээр манайхаас хэдэн дахин том ч бидэн шиг зэс, нүүрс, төмрийн хүдэр экспортологч орон. Гэлээ гээд эдийн засаг нь хямарсангүй. Тэр тусмаа тус улсын өсөлтийн

монголчуудыг гэжээ тэтгэсээр ирсэн эрдэнэт мал сүрэг гээд бүхий л бололцоо Монголд бүрджээ. Гэвч боломжийг бүрэн ашиглалгүй эдийн засгийн солонгоо сарниулсаар.

НАЙДВАР ДАГУУЛЖ БУЙ ХӨТӨЛБӨР

Өнгөрсөн сараас Монгол Улсад албан ёсоор хэрэгжүүлэхээр болсон “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн

хайлуулах, нүүрс шингэрүүлэх үйлдвэр байгуулж, газрын тосоо түүхийгээр нь гаргах биш, эхний ээлжинд дотоодын хэрэгцээг бүрэн хангах гээд шийдлээ хүлээж буй зорилтууд бий. Дараа нь ноолуур, мал аж ахуй, аялал жуулчлал, мэдээллийн технологийг уул уурхай лугаа хөгжүүлэх нь солонгын долоон өнгөний гол бүрдэл болох учиртай.

Бидний хөгжүүлж чадах мөртлөө чадахгүй байгаа салбар бол мал аж ахуй. Махны экспортыг жишээлж үзье. Хэдий олон малтай ч бид Орос, Хятадын махны хэрэгцээг дангаар хангах дийлэхгүй. Харин элдэв эм тариа хэрэглэдэггүй, “органик мах” хэмээгээд брэнд үүсгэж чадна. Үүнийг эрүүл ахуйн стандарт хангасан гэдгийг баталж чадвал Бээжингийн баячуудын хэрэгцээг монгол брэндийн махаар хангах боломжтой. Тэгвэл монгол малын мах кг нь 20-30 ам.доллараар экспортлогдох бололцоо бий.

Хэдийгээр олон улсын байгууллагууд Монголын хөдөө аж ахуйн боломжийг ам уралдан ярьдаг ч яг зориг гаргаад мөнгө өгчих хөрөнгө оруулагч цөөн байдгийг салбарынхан учирладаг. Учир нь байгаль, цаг уураас хэт хамааралтай, өндөр эрсдэлтэй салбар гэж үздгээс үүдэлтэй аж. Олон улсын хөрөнгө оруулагчдын зориг нь дутагч буй энэ салбарт Монголын төр дэмжлэг үзүүлж болно. Бас аялал жуулчлалын салбар байна. Мөн л мөнгө үгүйлсэн, санхүүжилтгүйгээс гагцхиад байгаа салбар. Хэрэв аялал жуулчлалыг эдийн засгийг солонгоруулах салбар гэж тодорхойлон төр бодлогоороо дэмжиж хувийн хэвшилтэйгээ хамтран ажиллал олон боломж бий.

ҮҮЛГЭН ЧӨЛӨӨНИЙ НАР

“Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлээ гээд эдийн засаг сэргэчихгүй гэдгийг шинжээчдээс эхлээд салбарын сайд нь хүртэл сануулж байгаа. Тус хөтөлбөрийн санхүүжилт Монголыг чиглээд эхэлсэн ч уг мөнгөөр яг ямар төслүүдээ хөдөлгөж, эсэх нь тодорхойгүй байна. 5.5 ам.долларын зээлийн багцын багагүй хэсэг нь төв банкныг чиглэх бол үлдсэн нь төсвийг алдагдлыг нөхөхөөр байгаа. Үүнийг л ашиглаад бид эдийн засгаа тэнхрүүлж, макро эдийн засгийн баттай суурийг бэхжүүлэх нь чухал байгаа юм.

Эс бөгөөс 2018 оны нэгдүгээр сарын 5-нд дуусах таван жилийн хугацаатай, 500 сая ам.долларын “Чингис” бондын төлбөр хүлээж байгааг санаарай. Цаашлаад 2021, 2022, 2023 он гээд шил шилээ дарсан өндөр үнийн дүн бүхий бондын төлбөрүүд хүлээж байгаа. Тиймээс сөхөрсөн эдийн засгаа сэргэхэд бидэнд

жил хагасын хугацаа л үлдээд байна. Үүлэн чөлөөний нар шиг хугацааг ашиглаад эдийн засгийн дорвитой өөрчлөлтийг хийж чадахгүй бол олон сая ам.доллараар хэмжигдэх өрийн эргэн төлөлт бидэнд боломж олгох болов уу.

Монгол Улсын Засгийн газрын 48 сарын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг УИХ-аас баталсан. Энэ зураглал ёсоор эхний 18 сарыг эдийн засгийн уналтыг зогсоож тогтворжуулахад зарцуулахаар төлөвлөсөн байдаг. Тэгвэл эхний зорилтоо эцэслэх, эдийн засгийн тогтвортой суурийг бэхжүүлэх удаах зорилтоо эхлүүлэхэд зургаа хүрэхгүй сар үлдээд байна. Ирэх 32 сард Засгийн газар, ОУВС амалсан эдийн засгийн бүтцийн шинэчлэлээ хийж чадах уу. Өмнөх шигээ зам тавиад, орон сууц бариад дуусгачихвал их улдаа гэхэд 2020 онд бид дахиад ч бадар бариад Вашингтоныг зорьж магадгүй.

» Хэрэв Монголыг чиглэх мөнгөний урсгалыг тогтвортой хөгжлийнхөө суурь болгоход зарцуулахгүй бол сүүлийн хоёр жил өрнөсөн хүндрэл хэдэн жилийн дараа дахиад л давтагдана.

» 1991 оны аравдугаар сард анхны “Стэнд бай”-ыг хүлээн авч, тэр цагаас хойш Монгол Улс тус сангийн тусламжийн таван ч хөтөлбөрийг хэрэгжүүлээд амжжээ.

» Биднийг хэдэнтэй унаж, босох зуур Австрали эдийн засгийн тасралтгүй өсөлтөөр дэлхийд дээд амжилт тогтоох гэж байна.

ОУВС-гийн бодлогын үндсэн зорилт аюулыг арилгах буюу гал унтраах. Тэр утгаар төсөв, төлбөрийн тэнцлийн хямралд орсон орнуудад тусламжийн гараа сунгаж байдаг. Өмнөх хөтөлбөрүүд шигээ ОУВС гурван жилийн дараа манай хямралын галыг унтраагаад Америк киноны баатарлаг үйлс бүтээсэн баатар шиг “нисээд” одчихно. Харин эдийн засгаа урт хугацаанд зөв залах нь бидний хийх ажил болоод үлдэнэ. Хэрэв Монголыг чиглэх мөнгөний урсгалыг тогтвортой хөгжлийнхөө суурь болгоход зарцуулахгүй бол сүүлийн хоёр жил өрнөсөн хүндрэл хэдэн жилийн дараа ахиад л давтагдана. Улмаар Монгол Улс хямралын тойргоос гарч чадахгүй, туйлдах вий. [ЗГМ]



Монголын эдийн засаг түүхий эдийн ханш даган дарцаг шиг хийсээд удаж байна.

С.Батсайхан / ЗГМ ©

Улмаар 1991 оны аравдугаар сард анхны “Стэнд бай”-ыг хүлээн авч, тэр цагаас хойш Монгол Улс тус сангийн тусламжийн таван ч хөтөлбөрийг хэрэгжүүлээд амжжээ. Өдгөө зургаа дахь хөтөлбөрөө хүлээн аваад буй. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн хугацаанд Монгол Улс 3-5 жилийн давтамжтай ОУВС-гийн тусламжийн хөтөлбөрт хэд хэдэн удаа хамрагджээ. Монголчууд зах зээлд шилжсэн 20 гаруй жилийн бараг талд нь ОУВС-тай хамтран нийгэм, эдийн засгийн бодлогоо тодорхойлсон байна. Өдгөө ч тэдний хяналт дор хөгжлийн бодлогоо удирдаж буй. Хэдийгээр хэзээ мөдгүй эрчээ авах зургаа дахь хөтөлбөрийн үр дүнг одоо ярих нь эрт ч өмнөх хөтөлбөрүүдийг харин өдгөө дүгнэж болно. Учир нь өнөөдөр бол очигдрийн үр дүн. Тэгэхээр эдийн засгийн эдүгээгийн нөхцөл байдал өмнөх таван хөтөлбөрийн ашиг тусыг тодорхойлж дөнгөнө гэсэн үг. Монголын одоогийн эдийн засгийг ажвал ОУВС-гийн хөгжлийн хөтөлбөрүүд нэр шигээ хөгжүүлж чадсан гэвэл эргэлзээтэй.

Бас өмнөх жилүүдийн жишгээр бол Монгол Улс 3-4 жилийн дараа дахиад ч бадар бариад ОУВС-гийн хаалга тогшиж мэднэ. Үүнийг хэлэхэд тус сангаас түрүүлж санал тавьж, “танайд туслаа” хэмээн биднээс гуйж байсан удаа үгүй. Харин

адил цацарсан олон салбарыг хөгжүүлнэ гэсэн үг. Ингэж түүхий эдэд түшиглэсэн эдийн засагтай улсууд өөрийгөө хамгаалдаг.

Бид ч олон тулгуурт эдийн засгийг цогцлоох талаар улиг болтлоо ярьж байна. Гэвч өнөөг хүртэл эдийн засгийн солонгыг тогтоон бариагүй хэвээр. Манай нийт экспортын 80 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн дангаараа бүрдүүлдэг. Хилийн чанадыг чиглэсэн нийт худалдааны 90 орчим хувь нь үндсэн долоон нэр төрлийн боловсруулаагүй түүхий эдээс бүрдэж байна. Монголчууд ярьсаар суугаад 20 гаруй жилийг үдчихжээ.

Хэдийгээр одоо хэр нь биеллээ олоогүй ч эдийн засгаа төрөлжүүлэх буюу солонгоруулах нь үе үеийн Засгийн газрын амин чухал бодлого хэвээр байх ёстой. Тийм ч учраас Монгол Улс урт хугацааны буюу 2015-2040 он хүртэлх хөгжлийн бодлогын төслийн гуравдугаарт эдийн засгийн төрөлжилтийг эрэмбэлжээ. Гэвч өнөөг хүртэл бүтцийн өөрчлөлтөө хийж чадсангүй. Тэгвэл ханш дагасан савлагаанаасаа хэзээ салж, хэдэн жил болоод гуйлга гуйдаг зангаа яаж засах вэ.

ХЯМРА.ЛААС ХОЛ УЛС

Уул уурхайд түшиглэсэн улс бүр бидэн шиг ханш даган савладаг уу. Биднийг Австрали эдийн засгийн тасралтгүй өсөлтөөр дэлхийд дээгүүрт ордог өргөн уудам газар нутаг, үржил шимтэй эдийн засгийн тасралтгүй

эхлэл цаг хугацааны хувьд Монголтой төстэй буюу 1991 оноос үүдэлтэй. Гэвч баялгаа зөв удирдсаны үр дүнд энэ улс уул уурхайн үнийн шуургаанаас өөрийгөө хамгаалах шүхэртэй болж чаджээ.

Боломжийг бүрэн ашиглалгүй эдийн засгийн солонгоо сарниулсаар

Австрали улс 1980-аад оноос төрийн өмчийг хувьчилж, эдийн засаг дахь төрийн зохицуулалтыг бууруулан, банкны салбарын зохицуулалтыг зөөллөсөн нь хөгжлийг нь өдөөсөн гэж шинжээчид тодорхойлдог. Нөгөө талаас Австралийн дэргэд бий болсон эдийн засгийн шинэ гүрэн Хятад тус улсыг өсөлт өөд хөтөлсөн гэж үздэг байна. Хэмжээг нь эс тооцвол Австрали, Монголын эдийн засагт ижил тал цөөнгүй бий. Гэвч тэд бүдрэлгүй урагшилж, бид унаж, босоор өдий хүрлээ.

Уг нь Монгол оронд хөгжин дэгжих асар өргөн боломж бий. Газарзүйн тэр бүр тохиогоод байдаггүй байршил, нэг хүнд ногдох хэмжээгээр дэлхийд дээгүүрт ордог өргөн уудам газар нутаг, үржил шимтэй эрүүл онгон хөрс, үеийн үед

хүрээнд манай эдийн засгийг солонгоруулж, тогтвортой өсөлтийн суурийг бэхжүүлэхээ ОУВС-гаас мэдэгдсэн. Гэхдээ олон жил бий болгож чадаагүй эдийн засгийн энэ бүтцийг яг хэрхэн хэрэгжүүлэх нь өнөөг хүртэл бүдгэр хэвээр байна.

ОУВС-гийн хөтөлбөрийн санхүүжилт, хувийн хэвшил дагасан хөрөнгө оруулалт гээд ойрын хугацаанд манай эдийн засгийг багаар бодоход 6-7 тэрбум ам.доллар чиглэхээр байгаа. Мөн манай зээлжих зэрэглэл өндийвөл олон улсын зах зээлээс дахиад ч бонд босгох төлөвлөгөө Засгийн газарт бий.

Ингээд тооцвол эдийн засгаа сэвхийтлээ босгоод ирэх санхүүгийн чадавч бүрдэнэ. Цаашлаад уул уурхайн бус салбарыг тэтгэх боломж нээгдэх юм. Гэхдээ эдийн засгийг солонгоруулах гээд олон салбарт хүч тарамдах хэрэгтэй юу. Харин аль салбарыг нь хөгжүүлснээр улсын эдийн засагт дорвитой хувь нэмэр болж, улсаа хөгжүүлэх вэ гэдгийг тодорхойлох нь чухал болохыг эдийн засагчид зөвлөдөг. Эхлээд уул уурхайгаа солонгоруулах хэрэгтэйг ч сануулдаг юм. Уул уурхайг солонгоруулна гэвэл алт, зэс, нүүрснээс гадна уран, газрын ховор металл, газрын тосны салбарыг адилхан хөгжүүлж, нэн ялангуяа нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх хэрэг гарна. Зэс

Ходоодны хорт хавдрын эсрэг

Хавдраар нас барж байгаа өвчтөний тоог бууруулах боломжтой

Ходоодны хавдраар өвчлөгсдийн 73 хувь нь таван жилийн дотор нас барж байна

Г.Оюунтөгс
@oyuntugsZGM

Монгол Улсын хэмжээнд хорт хавдрын өвчлөлийн хоёрдугаар байрт буюу нийт хорт хавдрын тохиолдлын 14.7 хувийг ходоодны хорт хавдар эзэлж байна. Харин уг өвчний тохиолдлоор манай улс дэлхийд хоёрдугаарт орж байгаа боловч нас баралтаараа тэргүүлдэг. Мөн жил бүр 500 орчим хүн уг өвчний улмаас амиа алддаг гэсэн харамсалтай судалгаа бий. Үүнээс үзэхэд хавдрын өвчлөл, нас баралт манай оронд жилээс жилд өсөх хандлагатай байгаа юм. Ходоодны хорт хавдар нь удамшлын суурин дээр орчны олон төрлийн хүчин зүйлс нөлөөлснөөр үүсдэг өвчин юм. Ходоодны хорт хавдар үүсгэгч хамгийн гол хүчин зүйл нь хеликобактерийн халдвар байдаг. Мөн тамхи, нитрит болон давсны өндөр хэрэглээ, епштейн Баррын вирусийн халдвар нөлөөлдөг гэж Хавдар өвчин судлалын эмч нар хэллээ. Учир нь судалгаагаар ходоодны доод хэсгийн хорт хавдрын нийт тохиолдлын 75 хувь нь хеликобактериас шалтгаалсан байдаг аж. Энэхүү өвчнөөр өвдсөн хүмүүсийн 30 хүрэхгүй хувь нь таван жил амьдардаг бөгөөд маш хорон явцтай, нас баралт өндөртэй өвчин юм. Дэлхийд ойролцоогоор жилд ходоодны хорт хавдрын нэг сая тохиолдол шинээр оношлогддог бол 723 мянган хүн уг өвчний улмаас нас бардаг аж. Уг өвчний нийт тохиолдлын 50 орчим хувь нь БНСУ, Хятад, Япон, зэрэг зүүн Азийн орнуудад тохиолддог.



С.Батсайхан / ЗГМФ

ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ОРНУУДЫН ТҮРШЛАГА

Хавдрыг эрт үед нь оношлуулбал бүрэн эмчлэгдэх боломжтой учраас ходоодны хорт хавдрын өвчлөл ихтэй БНСУ, Японд эрт илрүүлгийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нас баралтыг эрчимтэй бууруулжээ. Энэ тухай Солонгосын ходоодны хорт хавдрын нийгэмлэг мэдээлж байсан. Тодруулбал, 1995 онд БНСУ-ын ходоодны хорт хавдрын нийт тохиолдлын 28.6 хувь нь эрт үедээ оношлогдож байв. Үүнээс дөрвөн жилийн дараа буюу 1999 оноос эрт илрүүлгийн хөтөлбөр хэрэгжүүлснээр 2009 он гэхэд өвчлөлийн эрт үедээ оношлогдох хувь 57.7 хувь болж өссөн байдаг. Үүний үр дүнд 1993-1995 оны хооронд хавдраар оношлогдсон өвчтөнүүдийн таван жил амьдрах магадлал эрэгтэйчүүдэд 43, эмэгтэйчүүдэд 42.6 хувь байсан бол 2006-2010 оны хооронд

эрэгтэй 67.7, эмэгтэй 65.7 хувь болж өссөн үр дүн гарчээ.

Ходоодны хорт хавдраар дэлхийд жилд нэг сая хүн оношлогдож, 723 хүн нас бардаг

Өдгөө дэлхийд уг өвчний өвчлөөр тэргүүлж буй БНСУ нь нас баралтаараа дэлхийд 18 дугаар байрт, өвчлөөрөө Монгол Улсын дараа буюу гуравдугаарт жагсах болов. Харин Япон улс нас баралтаараа дэлхийд 18 дугаар байрт орж байна. Монгол орны хувьд ходоодны хорт хавдартай өвчтөний таван жил амьдрах магадлал ердөө 25 хувь байгаа нь нийт өвчлөлийн 85 орчим хувь нь хожуу шатандаа

илэрч байгаатай шууд холбоотой. Солонгос, Япон зэрэг орон эрт илрүүлгийн шинжилгээ, оношилгооны хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлснээр уг өвчний нас баралт жил ирэх хавдар буурч байгаа бөгөөд нийт нас баралтын тохиолдлоор манай улсаас хоёр дахин бага болжээ.

МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖИЖ БҮЙ ХОРТ ХАВДРЫН ЭМЧИЛГЭЭ

Хэрэв эрт үедээ оношлуулбал ходоодны хорт хавдрыг уян

дурангийн аргаар дотор талаас нь салст болон салстын доод давхаргыг хуулах аргаар эмчлэх боломжтой. Харин хожуу шатны хорт хавдрын эмчилгээ нь өртөг өндөртэй учраас мэс засал, клиник хавдар судлал, хими эмчилгээ, хөнгөвчлөх зэрэг эмчилгээг цогцоор нь хийдэг ч үр дүн маш муу байдаг. Хавдар судлалын үндэсний төв жилд дунджаар ходоодны хорт хавдрын 300 орчим мэс засал хийдэг бөгөөд манай оронд дээр дурдсан эрт үеийн илрүүлэлтэд дурангийн



Дэмжигч байгууллага



аргаар салст хуулах ESD EMR эмчилгээний аргыг хэрэглэдэг. Уг өвчнөөр өвчилж, хожуу үедээ оношлогдсон 50 хүртэлх насныхны амьд үлдэх магадлал 16-22, 70-аас дээш насныхан 5-12 хувьтай байдаг байна. Иймээс нийт өвчлөгсөд болон нас баралтын тоо илүү нэмэгдэхээс өмнө ходоодны хорт хавдрын эрт үеийн илрүүлгийн хөтөлбөрийг улсын хэмжээнд эхлүүлж, иргэдийг эрт үеийн шинжилгээ, оношилгоонд хамруулах нэн шаардлагатай байна. [ЗГМ]

ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛ

Ходоодны хорт хавдрын нас баралтаар дэлхийд эзлэх байр (нийт хүн амын)




Дэлхийд тэргүүлж буй орнуудын хорт хавдрын өвчлөл, нас баралтын харьцуулалт (100,000 хүн ам тутамд)

Монгол Улсын хорт хавдрын өвчлөл



Хавдрын илэрч буй үе шат



ХСҮТӨ

ЗГМ: тодруулга

Д.Дэлгэрмөнх: Хүмүүс ходоодоо дурандуулах нь нэмэгдсэн



С.Батсайхан / ЗГМФ

Орон даяар хоёр сар гаруй хугацаанд Ходоодны хорт хавдрын эсрэг аян өрнүүлээд байна. Энэ хугацаанд гарсан үр дүнгийн талаар Хавдар судлалын үндэсний төвийн мэс заслын эмч Д.Дэлгэрмөнхөөс тодрууллаа.

-Ходоодны хорт хавдрын эсрэг аян өрнүүлээд багагүй хугацаа өнгөрсөн байна. Аян эхлүүлснээс хойш ямар үр дүн гарч байна вэ?

-Ходоодны хортой хавдрын эрт үеийн илрүүлэг аян эхэлсэнтэй холбоотойгоор хүмүүс ходоод дурандуулах нь эрс нэмэгдсэн. Хөдөө орон нутаг болон дүүргийн эмнэлэгт ходоодоо дурандуулж, хавдрын сэжигтэй хүмүүс манай эмнэлгийн нарийн шинжилгээнд хамрагдаж байна. Тэгэхээр төслийн хэрэгжилт сайн байгаа юм.

-“Элэг бүтэн Монгол” төсөл өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлж, иргэдийг эрт үеийн оношилгоонд үнэ төлбөргүй хамруулсан. Тэгвэл ходоодны хорт хавдрын эсрэг аян үүнтэй ижил түвшинд хэрэгжих боломжтой юу?

-“Элэг бүтэн монгол” төсөлтий адил ходоодны хорт хавдрын эрт

үеийн илрүүлэг төслийг ирэх жил дахин үргэлжлүүлэхээр төлөвлөж байна.

-Өнөөдөр Хавдар судлалын үндэсний төвд хандах өвчтөний тоо нэмэгдсэн үү. Ачаалал их байна уу?

-Уг нь баяр наадмын өдрүүд ойртох тусам хүн багасдаг. Гэтэл сүүлийн үед эмнэлгийн ачаалал нэмэгдэх болсон. Урьд жилүүд болон өмнөх саруудыг бодвол ачаалал эрс өссөн.

-Одоогийн байдлаар эрт үеийн илрүүлгийн оношилгоо, шинжилгээнд хэчнээн иргэн хамрагдсан бэ?

-Эрт үеийн илрүүлэгт ийм хэмжээний хүн хамрагдсан гэсэн нарийн тоог гаргахад хэцүү. Ерөнхийдөө иргэд шинжилгээнд хамрагдах нь нэмэгдэх болсон.

-Эрт үеийн илрүүлэлтэд хамрагдсан иргэдийн ихэнх нь эмэгтэйчүүд байдаг уу?

-Үгүй ээ. Ходоодны хортой хавдар нь ихэвчлэн эрэгтэй хүмүүсийн дунд илүү тохиолддог бөгөөд гол төлөв 35-60 орчим насны иргэд хамрагдаж байна. [ЗГМ]



“МОНГОЛЫН ИПОТЕКИЙН КОРПОРАЦИ ОССК” ХХК ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР МЭРГЭЖИЛТЭН ШАЛГАРУУЛЖ АВНА

Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг: “МИК Групп” компани болон “МИК ОССК” ХХК, түүний үүсгэн байгуулсан ТЗК-ийн хөрөнгийг удирдах, ирээдүйн мөнгөн урсгалыг төсөөлөх болон бусад хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үр ашгийг тооцох, төсөөлөх, түүний гүйцэтгэлд хяналт тавих, шинжилгээ хийх, санхүүгийн төлөвлөлт, санхүү, хөрөнгө оруулалтын болон актив-пассивын бүтэц болон бодлогыг тодорхойлох, гадаад болон дотоод зах зээлийн судалгаа хийж мэдээллээр хангах. Актив Пассивын хорооны нарийн бичгийн үүрэг ажлыг гүйцэтгэх.

Ажлын байранд тавигдах шаардлага:

- Банк санхүү, эдийн засаг, санхүүгийн удирдлагын чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй;
- Банк, санхүүгийн байгууллага болон аж ахуй нэгжийн санхүүгийн удирдлага, төлөвлөлт болон нягтлан бодох бүртгэл, хөрөнгө зохицуулалтын чиглэлээр 2 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай;
- Санхүүгийн мэргэжлийн Англи хэлний зөв бичгийн болон ярилцлага хийх өндөр чадвартай;
- Хэрэглээний болон санхүүгийн программ хангамж ашиглах чадвартай;
- Мэргэшсэн нягтлан бодогч (CPA), Олон улсын мэргэшсэн нягтлан бодогч (ACCA), Мэргэшсэн санхүүгийн шинжээч (CFA) түвшиний анхан шатлалын шалгалтыг өгч гэрчилгээ авсан бол давуу тал болно;

Нэмэлт ерөнхий шаардлага:

- Хариуцсан ажилдаа бүтээлч сэтгэлгээтэй, идэвхи санаачлагатай, ажлын цаг ашиглалтын зохион

- байгуулалт сайтай байх;
 - Санаачлагатай, багаар болон бие даан ажиллах;
 - Багаар болон бие даан үр дүнтэй ажиллах, удирдан зохион байгуулах чадвартай;
 - Шударга, хөдөлмөрч, компанийн сайн засаглалын мэдлэгтэй, ёс зүйтэй байх;
 - Ажлыг төлөвлөх, манлайлах, удирдан зохион байгуулах дүгнэлт хийх, шийдвэр гаргах чадвартай;
 - Хувийн зохион байгуулалт сайтай, хариуцлагатай, харилцааны соёлтой;
 - Ажлын ачаалал даах чадвартай, өөрийгөө дайчлан ажиллах боломжтой;
 - Ёс зүйн хэм хэмжээ, хөдөлмөрийн сахилга батыг дээдлэн сахидаг;
 - Урт хугацаанд тогтвор суурьшилтай ажиллах.
- Бүрдүүлэх материал:**
- Ажилд орохыг хүссэн өргөдөл (гараар бичсэн);
 - Анкет (www.mik.mn цахим хуудаснаас татаж авна уу);
 - Дипломын хуулбар (нотариатаар баталгаажуулсан байх);
 - Иргэний үнэмлэхний хуулбар (нотариатаар баталгаажуулсан байх);
 - 3 үеийн түүх (гараар бичсэн);
 - Өмнө хийж байсан ажил, туршлагын талаар товч бэлтгэсэн мэдээлэл;
- Сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтэй иргэд материалаа delgermunkh@mik.mn хаягаар болон СБД-ийн 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, 11-А хаягт орших Худалдаа хөгжлийн банкны 10-р давхарт 2017 оны 07-р сарын 07-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Жич: Анкетийн сонгон шалгаруулалтанд тэнцсэн ажил горилогч нартай холбоо барина.
Утас: 11-328267 (827), Вэбсайт: www.mik.mn, И-мейл: info@mik.mn



“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шуудаг ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгмийн мэдээллийн алба

Эдитор Б.Гандолгор
Утас: 99901483

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба

Эдитор Б.Баяртогтох
Утас: 99901532

Гадаад контент, соёл энтертайментын алба

Эдитор Р.Оюунцэцэг
Утас: 99901621

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Э.Энхбаатар

Утас: 99903578

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,

1 хороо, Энхтайваны өргөн чөлөө,

“Бло Скай тауэр” 407 тоот

Улсын бүртгэлийн дугаар: 1024

Утас: 70103131,

Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР

ubinfo.mn

Дугаарын удирдагч

Б.Баяртогтох



Экологи

"Шавжинд гурван жил идүүлсэн ой сэргэхгүй"



С.Батсайхан / ЗГМ

Хөнөөлт шавжинд 130 мянган га ой сүйдээд байна

З.Цэлмэг
@tselmegZGM

Ойд түймрээс дутуугүй хөнөөл учруулагч хортон шавжтай тэмцэх ажил ид өрнөж байна. Энэ жил хор хөнөөл ихтэй Сибирийн хүр эрвээхий идэвхжлийн үе тохиож буй тул яаралтай устгах шаардлагатай гэдгийг мэргэжилтнүүд онцлов.

Сибирийн хүр, өрөөсгөл хүр зэрэг эрвээхий хөгжлийн хүрэнцэрийн үедээ цоо эрүүл шинэс модны шилмүүсийг үгүйртэл иддэг байна. Ингэж доройтсон үед нь модлогоор хоологч шавж модруу орсон тохиолдолд тэр чигтэй босоогоороо хатаж мөхдөг аж. Манай улсын уур амьсгал судлаачдын тооцоогоор хөнөөлт шавжинд нэрвэгдэх ойн талбайн хэмжээ цаашид 2-3 дахин нэмэгдэх тооцоо бий. Тиймээс хортон шавжтай тэмцэх ажлыг нарийн тандалт судалгаатай хийх шаардлагатайг БОАЖЯ-ны Ойн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн Д.Жагдаг ярилаа.

-Энэ жил ойн хортон шавжны тархалт өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад хэр их байна вэ?

-Хортон шавжны тархалтыг тогтоохоор Ойн судалгаа, хөгжлийн төвийн баг Төв аймагт, "Мөнх ногоон ой" гэх байгууллага баруун бүсэд ажиллаж байна. Харин зүүн аймгаар мэргэжлийн судлаачид явж байгаа. Мэдээлэл эцсийн байдлаар ирээгүй тул тархалтын судалгааг одоохондоо бүрэн хэлэх боломжгүй. Гэхдээ судалгааны явцаас харахад өмнөх 2-3 жилд яacobсоны төөлүүрч эрвээхий их хэмжээгээр тархаж, хохирол учруулж байсан. Зөвхөн өнгөрсөн жил л гэхэд хөнөөлт шавжны голомттой 591 мянган ам метр талбайн дийлэнхийг энэ шавж эзэлсэн. Харин энэ жил Сибирийн хүр эрвээхий идэвхжиж байна. Энэ эрвээхийн хөнөөл онц аюултай.



-Тархалтаас сэргийлэх бэлтгэл ажил хэр хангагдсан бэ?

-Өнгөрсөн жил нийслэлийн ногоон бүсээр өрөөсгөл хүр эрвээхий тархаж, зуслангийн газраар их орж ирсэн. Тиймээс тархалтыг нь хязгаарлаж зорилгоор өнгөрсөн намар Төв аймгийн Батсүмбэр сум, Сэлэнгэ аймаг, нийслэлийн ногоон бүсийн 60.8 мянган га талбайд энэ эрвээхийн өндгийг түүсэн.

-Монгол орны ойн хэчнээн хувь нь хортон шавжийн улмаас доройтоод байна вэ?

-Хөнөөлт шавжинд нэрвэгдээд, хатаж хуурайшсан ойн талбай 130 гаруй мянган га-аар хэмжигдэж байна. Голомт үүсч, улайсан ч тэмцлийн арга хэмжээ зохион байгуулснаар эргээд сэргэсэн ойн талбай олон бий.

-Хортон шавжинд идэгдсэн ой сэргэх найдвар хэр вэ?

-Ой мод шавжинд 2-3 жилийн хугацаанд идэгдсэн бол хатаж хуурайшаад дуусна. Эхний 1-2 жилд буюу хортон шавжийг яг идэж байх хугацаанд нь тэмцэж, устгаж чадвал эргэж сэргэдэг. Тиймээс л шавжны тоо толгойг зохистой хэмжээнд барьж байхын тулд жил бүр тэмцлийн арга хэмжээ зохион байгуулдаг юм.

-Устгалыг хэдийгээр явуулдаг вэ?

-Шавжийн төрөл зүйлээс хамаарч хугацаа харилцан адилгүй. Өрөөсгөл хүр эрвээхийн өндөг түүх ажлыг дөрөвдүгээр сараас зургадугаар сарын эх хүртэл хийдэг. Харин хүрэнцэртэй болоод, модондоо хөнөөл учруулдаг нь 6-7 дугаар сарын дунд үе тул тэмцлийн ажил тэр хүртэл үргэлжилнэ.

-Дэлхийн дулаарлын улмаас ойн хортон шавж олширно гэсэн тооцоог манай уур амьсгал судлаачид гаргасан байсан. Энэ нь ямар учиртай юм бэ?

-Сүүлийн жилүүдэд цаг уур дулаарч буйг хүн бүр мэдэж

байгаа. Агаарын температур нэмэгдэх нь шавжинд амьдрах таатай нөхцөл бүрдүүлдэг. Нэг ёсондоо нэг эмэгчингээс гарч буй 300-400 гаруй өндөг бүгд шавж болох боломж бүрдэнэ гэсэн үг. Уг нь сэрүүн, эрс тэс, цочир хүйтэрдэг байсан үед бол тоо толгой нь хязгаарлагдаж, зохистой хэмжээндээ байсан. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас тийм нөхцөл байхгүй боллоо.

-Энэ бүх өөрчлөлттэй дасан зохицохын тулд ямар аргаар тэмцдэг юм бэ?

-Биологийн болон байгаль орчинд сөрөг нөлөөгүй аргууд хэрэглэж байна. Монголын эрдэмтдийн гаргаж авсан төрөл бүрийн нутгийн омгийн бактерийг энэ жилээс хэрэглэж байна. Мөн гэрлийн урхи, эмэгчин эрвээхийн шингэнээр эрэгчинг нь урхидаж устгадаг арга бий. Энэ жилээс уг шавжийг гаднаас нь идэж, дотроос нь шимэгчилдэг байгалийн дайсныг нь үржүүлэх замаар устгахаар судалгаа хийгээд явж байна.

-Сүүлийн арга олон улсад хэр түгээмэл вэ?

-Бид Ойн судалгаа хөгжлийн төвийн судлаачидтай хамт саяхан БНХАУ-ын ойн хүрээлэнд очиж ажилласан. Яг энэ чиглэлээр хийж байгаа ажлыг нь үзэж, туршлага судалж байна.

-Хортон шавж устгахад хэр зэрэг зардал гардаг вэ?

-Энэ жилийн хувьд гурван тэрбум төгрөгөөр тархалт, голомт ихтэй томоохон талбайг хамруулна. 150 мянган га талбайд тэмцлийн ажил зохион байгуулахаар төсөвлөсөн. Өмнөх жилүүдэд хөрөнгө мөнгөний асуудлаас болж голомттой талбайгаа бүрэн хамруулж чаддаггүй байсан тул дараа дараагийн жилүүдэд устгалын ажил үргэлжилдэг. Уг нь хөнөөлт шавжийн тархалтыг бүрэн хяналтдаа авч чадвал тогтоох боломжтой. 2016 онд 591 мянган га талбай голомжтой байхад 500 гаруй сая төгрөгөөр 70 мянган га-д л устгал хийж байгаа юм.

-Хортон шавжтай жил бүр тэмцдэг нь зөвхөн хөрөнгө мөнгөөс шалтгаалаагүй болов уу?

-Тийм ээ. Жил бүр л баахан мөнгө төсөвлөөд тэмцдэг боловч үр дүн байдаггүй юм уу гэх хардлага хүмүүсийн дунд бий.

Би үүнд тайлбар өгмөөр байна. Ерөөсөө онц их хөнөөл учруулдаг 5-6 төрлийн шавж тус бүрийнх нь биологийн онцлог өөр. Өмнөх 2-3 жилд яacobсоны хүр эрвээхийн олшролын үе байсан. Энэ үед Архангайн ихэнх ой нэлэнхүүдээ улайж байсан бол энэ жилээс бууралтын шатандаа орчихсон. Энэ нь нэг талаар тэмцлийн үр дүн юм. Гэтэл энэ жил өөр төрөл нь олшроод эхэллээ. Өөр төрөл зүйл идэвхжсэнээр голомттой газрын байрлал ч өөрчлөгддөг. Одоогоор Сэлэнгэ, Хэнтийд байдал хүнд байна. Ирэх 2-3 жилийн дараа өөр нэг төрөл зүйл нь олшрох жишээтэй. Ер нь 3-4 жилийн давтамжтай эдгээр хортон шавж идэвхждэг юм. Сибирийн хүр эрвээхий хоёр жилийн циклтэй иддэг амьтан тул ойд маш их хөнөөлтэй.

-Хортон шавж ойн доройтлын хэчнээн хувийг эзэлдэг вэ?

-Түймэртэй адил ойг доройтуулдаг гол хүчин зүйл. Энэ жил түймэр ихтэй байна. Түймэрт доройтсон ойд шавж олшрох нөхцөл бүрддэг. Хүнээр бол дархлаа нь суларч, олон өвчинд өртөмтгий болж байна гэсэн үг.

-Ер нь цаашид тэмцлийг ямар маягаар явуулах вэ?

-Хяналт, мониторинг сайн хийх хэрэгтэй байна. Орон нутаг дахь анхан шатны нэгж болох ойн анги, байгаль хамгаалагчид ямар шавж гарч, олширч буйг судалгааны байгууллагуудад мэдэгдэж байх хэрэгтэй. Мэдээллийн дагуу судлаачид газар дээр нь очиж тандан судалгаа хийгээд, ямар шавж хэзээ олширохыг урьдчилан тогтооцон хэрэгтэй. Үүний зэрэгцээ нөлөөлөлд өртөж буй ойдоо мониторингийн суурин цэг олноор байгуулбал шавжны олширолт, бууралтыг нарийн тогтооход маш их ач холбогдолтой.

-Байнгын голомттой болдог шалтгаан юу вэ. Ийм голомт хэр олон бэ?

-Ер нь шавж олширч буй голомтууд түймэрт автсан, хүний нөлөөлөлд өртсөн ойн санд л бий. Хэнтий, Хөвсгөлийн том тайгуудын мод улайтлаа идүүлдэггүй нь хүний нөлөө байдаггүйтэй холбоотой. Хүний үйл ажиллагаа ойн экологийн тэнцвэрийг алдагдуулдаг учир ой доройтож, хортон шавжинд идэгдэх нөхцөл бүрддэг. [ЗГМ]

ТАНИН МЭДЭХҮЙ

Хүйтний хагарал

Монгол орны цэвдэгт үзэгдлүүдээс

Өвлийн улиралд чийглэг хөрс хөлдөхөө эзлэхүүнээрээ тэлж, хагардаг. Энэ хагарал гол төлөв элсэнцэр, шавранцар хөрсөнд үүсдэг онцлогтой. Эхэндээ 5-10 см өргөн, нэг метр орчим гүн ан цавууд үүснэ. Тэдгээр ан цав чулуулгийн төрлөөс хамааран олон талт, элдэв өнцөгтийн сүлжээ бий болгодог. Жилээс жилд хөрс хөлдөх бүрт ан цав

томорч, тоо нь ч нэмэгддэг.

Хүйтний хагарал үзэгдэл хамгийн элбэгтэй газар бол Дархад хөрс хөлдөх хагарал гүн 10 м хүртэлх байх нь ч бий. Хагарлын ан цаваар ус орж хөлдөөд, мөсөн шаантаг үүсгэдэг. Хүйтний хагарал нь дөрвөлжин, тав, зургаан өнцөгт, шугаман хэлбэртэй байх нь элбэг. Харин жижиг хагарлууд гол нуурын хөндийн элсэнцэр, шавранцар хурдсанд үүсдэг байна. [ЗГМ]

Ертөнцийн төгсгөлийг зураглажээ

Хотжилтын улмаас биологийн олон янз байдал хэр зэрэг аюулд орж буйг зурагласан газрын зураг улам ихсэх төлөвтэй.

Зураг зүйч Абрахам Ортелиус 1570 онд "Ертөнцийн театр" хэмээх орчин үеийн газрын зургийн анхны хувилбарыг бүтээжээ. Газар зүйн их нээлтийн ид үед уран гоёор зурагласан Ортелиусын бүтээлийн тусламжтай европчууд дэлхийг шинээр харах болсноор олон газар орныг нээж, колоничилж эхэлсэн. Ертөнцийн төгсгөлийг зөгнөсөн гэгдэх эл бүтээл тухайн үедээ цэнхэр гарагийн мөхлийг ёрлоогүй нь мэдээж. Харин Ортелиусын мэддэг ертөнц байв.

Хүн төрөлхтөн байгалийн нөөц баялгийг шавхагдашгүй их хэмээн бодож, үр дагаварыг нь тооцохгүйгээр замбараагүй хэрэглэж эхэлснээр ертөнцийн мөхлийг далласан гэдгийг

дэлхийн экосистем тэр чигтээ аюулд орчихоод байна. Хот төлөвлөлтийн буруу бодлого нь эмзэг болсон экосистемд учруулах дарамтыг нэмэгдүүлж буйг Уиллер онцлов. Хэдийгээр хот төлөвлөлтийн концепц оршин суугчдын ая тухыг байгаль хамгаалалтай хослуулах болсон ч энэ мөрөөдөл биелэхэд урт хугацаа бий.

Сүүлд бүтээсэн газрын зурагт дүрсэлснээр НҮБ-ын өвд бүртгэгдэх био төрөл зүйлийн 36 халуун цэг байгаа аж. Энэ газар нутгаас 2020 он гэхэд 17 хувийг нь дэлхийн 196 орны нэгдэн орсон НҮБ-ын Биологийн төрөл зүйлийн тухай конвенцид багтаах нь уг газрын зургийг бүтээсэн эрхийн зорилго юм.

Хамгаалах шаардлагатай биологийн төрөл зүйлийн 36 халуун цэгт хамгийн багадаа 300 мянган хүнтэй 422 хот бий



Пенсильванийн их сургуулийн лэндскеп архитектурын мэргэжилтэн Ричард Уиллер ярьж байна. Уиллерийн шинжсэнээр Ортелиусын бүтээлд дэлхийн унаган байгаль, экосистем хөндөгдөөгүй байжээ. Харин 4.5 зууны дараа байдал бүхэлдээ өөрчлөгдөөд буй. Нэр нь үл мэдэгдэх, биологийн төрөл зүйлийг хамгаалахад амьдралаа зориулж яваа нэгэн эрхийн бүтээсэн газрын зургаас үзвэл

гэнэ. "Дэлхийн хүн амын тоо энэ зууны төгсгөл гэхэд 10 тэрбумд хүрнэ гэж тооцвол хотжилт болон экосистемийн хоорондын зөрчил улам нэмэгдэнэ" гэж Иелийн их сургуулийн мэргэжилтнүүд дүгнэжээ.

Тиймээс лэндскеп архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтнүүдийн үүрэг оролцоо байгаль хамгаалагчдаас дутуугүй их гэдгийг судлаачид сануулж байна. [ЗГМ]

ЗӨВЛӨХ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАРЛАЛ

Үндэсний Хөгжлийн Газар (ҮХГ) нь "Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд"(ДТХЗ) болон "Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"(МУТХҮБ-2030)-г хэрэгжүүлэхтэй холбоотой бодлогын уялдааг хангах, хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь урт, дунд хугацааны бодлогын уялдааг хангах, хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, Монгол Улсад хүчинтэй хэрэгжиж буй бодлогын баримт бичгүүдэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд ҮХГ-т техникийн туслалцаа үзүүлэхэд чиглэнэ.

Ажлын зорилго:

- Бодлогын уялдаа, тэргүүлэх чиглэлийг ДТХЗ болон МУТХҮБ-2030-тай нийцүүлж, улсын хөрөнгө оруулалт, төсвийн хүрээтэй уялдуулан тодорхойлох;
- Хөгжлийн урт хугацааны бодлогын зорилтуудтай өнөөгийн байгаа бодлогын баримт бичгүүдийн нийцтэй байгаа эсэхэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажилд удирдамж болгох бодлогын үнэлгээ хийх, хүрэх үр дүнг тодорхойлох аргачлал, арга зүйг боловсруулах;
- Бодлогын баримт бичигт үнэлгээ хийх үйл явцыг уялдаа холбоотой, оролцогч талуудын тал бүрийн оролцоотой явуулах.

Уг зөвлөх үйлчилгээг хамгийн багадаа 4 зөвлөхтэй хуулийн этгээд (төрийн бус байгууллага, зөвлөх үйлчилгээний компани эсвэл эрдэм шинжилгээний байгууллага) 5 сарын хугацаанд гүйцэтгэнэ.

Мэдүүлгээ ирүүлж буй байгууллага нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээлэл (сонирхлоо илэрхийлсэн албан бичиг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт, татварын болон нийгмийн даатгалын тодорхойлолт, улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, сүүлийн 3 жилийн санхүүгийн баталгаажуулсан тайлан, хөгжлийн бодлого, төрийн захиргааны чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан 7-с доошгүй жилийн туршлага, ажиллах боловсон хүчний боловсрол, ур чадвар, туршлагын талаарх мэдээлэл)-ийг ирүүлнэ. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.


Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг тус газрын www.nda.gov.mn вэб хуудас болон onon.kh@nda.gov.mn и-мэйл хаягаар авна уу.

Мэдүүлгээ 7 дугаар сарын 5-ны өдрийн 15.00 цагаас өмнө дордурдсан хаягаар ирүүлнэ үү.

Үндэсний хөгжлийн газар, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн Үндэстний Гудамж 5/1, Засгийн газрын II байр (ХБТХ-ийн мэргэжилтэн Х.Онон, өрөөний дугаар- 201, Утас: 261575)

ЗГМ: ИНФОГРАФИК

Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ялгарах CO2-ийн хэмжээ



Спорт

“Медалиа хаячихаад ямар нүүрээрээ гэртээ харих вэ”

Түүний хувьд нэг медалиа алдах юу ч биш бололтой

Б.Энхжин
ЗГМ

Дэлхийн шилдгүүд л оролцдог олимпын наадмаас “амь дүйж” авсан медалиудаа хулгайд алдсан явдал цөөнгүй тохиолддог. Эсвэл анхаарал болгоомжгүй байдлаасаа болж, “Салан баавгай”-н үлгэрийг амилуулсан нэгэн ч байх. Тухайлбал, бейсболын “Чикаго Уайтсокс”-ын тоглогч, Алексей Рамирес Кубын шигшээ багт долоон жилийн турш хүчин зүтгэхдээ “Афин-2004” олимпоос алтан медаль хүртсэн билээ. Доминикан, дараа нь Чикагод тоглож, алдрын түүхээ баяжуулсан тэрбээр хамгаас нандин медалиа хаа нэгтээ гэсэндээ туйлын харамсдаг нэгэн. Гэхдээ “Уайтсокс”-ын эзэн Жерри Рейнсдорф ОУОХ-нд хүсэлт гаргасны дагуу түүнд уг медалийн хоёр дахь хувийг гардуулсан юм. Үүний дараа тэрбээр “Надад үнэхээр сайхан санагдаж байна. Афины олимпоос медаль хүртсэн тэр үе сэтгэлд минь өөрийн эрхгүй буулаа” хэмээн өгүүлжээ.

Олимпын 23 алтан медальт, АНУ-ын нэрт сэлэгч Майкл Фелпс Лондоны олимпод уралдахаасаа өмнө “60 минут” шоу нэвтрүүлэгт оролцсон. Энэ үед түүний медалийн цуглуулгад нэг медаль дутуу байв. “Таны нэг алт хаана байна” хэмээн гайхсан сэтгүүлчийн асуултад “Үнэндээ энэ талаар мэдэх юм алга. Надад медалиа хадгалдаг гар цүнх байдаг юм. Уг нь би үүнийг найдвартай гэж бодсон ч нэг медалиа алга болгочихсон” хэмээн ярьжээ. Түүний хувьд нэг медалиа алдах юу ч биш бололтой.

Түүний нутаг нэгт скелетонч Тристан Гейл хэзээ ч супер од байж үзээгүй боловч “Солт-Лейк-Сити-2002” олимпоос алтан медалиар энгэрээ мялаасан азтан. Гэвч хэдэн жилийн өмнө түүний гэрт хулгайч орж, хуримын бөгж, компьютерийг нь хамагдаа медалийг нь бас авчихжээ. Цагдаа нар долоо хоногийн турш шуурхай ажилласны дүнд гэмт этгээдийг баривчилж, медаль нь эзэндээ



Түүний цуглуулгад нэг медаль дутуу байв. “Таны нэг алт хаана байна” хэмээн гайхсан сэтгүүлчийн асуултад “Үнэндээ энэ талаар мэдэх юм алга” хэмээн хариулжээ.

очсон байна.

Медалиа хаана ч хамаагүй хадгалдаг хайхрамжгүй хүмүүсийн нэг бол олимпын хошой аварга, сноубордч Шон Уайт. Америк эр медалиудаа номны завсар хадгалдаг байж. Нэг удаа ээжийнхээ машиныг унаж яваад алтан медалиа хувцасны халаасанд хийчихжээ. Гэтэл ээж нь мэдэлгүй хими цэвэрлэгэнд өгсөн гэнэ. Медалиа мартсан тамирчин өнөөх газарт очиход аль хэдийнэ цэвэрлэсэн байж таарчээ. Ажилчид хувцасны халаасанд ямар ч зүйл байгаагүй гэж түүнд тайлбарласан гэнэ. Олимпын медаль олсон хүн буцааж өгөхийг хүсэхгүй нь ойлгомжтой.

Америкийн өөр нэг тамирчин, Бээжингийн олимпын 4x100 м-ийн буухиа гүйлтэд аваргалсан Брендан Хансен Филадельфиас Техас руу нисэж явахдаа мөн л медалиа гээчихжээ. Тиймээс

Олимпын медаль олсон хүн буцааж өгөхийг хүсэхгүй нь ойлгомжтой

агаарын тээврийн компани, цагдаа, АНУ-ын усанд сэлэлтийн холбоонд энэ тухайгаа хэлж, цаг алдалгүй хайсны хүчинд гэсэн медалийг нь нэгэн оюутан охин олсныг мэдсэн байна.

Пан-Америк болон улсынхаа аварга, Лондоны олимпын хүрэл медальт бразил жүдоч Фелипе Китаиди 23 насны төрсөн өдрөөрөө медалийн болзол хангасан юм. Шагнал гарданаас хоёр хоногийн дараа тэрбээр хайхрамжгүй байдлаасаа болж, медальдаа сэв суулгасан

гэнэ. Бразилийн УОХ-ноос энэ бүх байдлыг бичиж, уучлалт хүссэн захидлыг ОУОХ-нд илгээгээд медалийг нь сольж өгөхийг уламжилсан ч тэдний хүсэл талаар болсон удаатай.

Голландын сэлүүрт завинь тамирчин, Атлантын олимпын аварга Дидерик Симоны гашуун туршлагаас өгүүлэв. Афины олимпоос мөнгөн медаль хүртсэн баяраа нөхөдтэйгөө хэсэг тэмдэглээд өрөөндөө ирэхдээ тэрбээр медалиа гээчихсэн байв. Энэ тухайгаа Грекийн цагдаа нарт мэдэгдээд “Медалиа олохгүй бол ямар нүүрээрээ эх орондоо очих вэ” хэмээн өгүүлжээ. Аз болоход нэгэн таксинь жолооч алдсан зүйлийг олж тус болсон бөгөөд завьчин эр түүнд баярласан сэтгэлээ илэрхийлэн марк дурсгажээ.

Бээжингийн олимпын хос байны төрөлд түүрүүлсэн мэр-

гэн буудагч Уолтон Эллер нэгэн удаа халааснаасаа медалиа алдсан байжээ. Гэхдээ түүний алтан медаль төдөлгүй олдсон юм. Гэтэл дараахан нь түүний найз Кари Кожелл Бээжингийн олимпоос зүүсэн хүрлээ хайхралгүй халаасалж яваад гэснийг нь цэвэрлэгч бүсгүй олоод өөрийн медальдаа анхаарал хандуулахыг зөвлөжээ. Иймэрхүү явдал 1936 онд ч гарч л байв. Берлиний олимпын өндрийн харайлтын төрөлд түүрүүлсэн Канадын Данкан МакНафтан жилийн дараа алтан медалиа машинаасаа алдчихжээ. Тухайн үед уг медалийг дахин олгох боломж байгаагүй учраас хоосон хоцроход хүрсэн байна. Дэд аваргаар шалгарсан түүний найз Боб ван Осдел олон жилийн дараа буюу нас барахынхаа өмнө өөрийн медалиа нөхөртөө бэлэглсэн нь Данканы сэтгэлийг ихэд хөдөлгөсөн түүхтэй. [ЗГМ]

ТОВЧХОН

» БУУДЛАГА

Германы Зуль хотод залуучуудын ДАШТ эхэллээ. Тус тэмцээнд Монголоос Э.Энхмаа, Ц.Анударь, Ө.Төгөлдөр, О.Есүгэн, Т.Золжаргал гэсэн таван тамирчин оролцож байна.

» САГСАН БӨМБӨГ

“Оклахома”-гийн холбогч Р.Уэстбрук NBA-ийн 2017-2018 оны улирлын үнэ цэнэтэй тоглогчоор тодорлоо. Тэрбээр өнгөрсөн улиралд онооны аварга болсноос гадна трипл-дабл дунджилж, энэхүү үзүүлэлтэд хүрсэн хоёр дахь сагсчин болсон юм. Харин улирлын шилдэг хамгаалагчийн шагнал “Голден Стэйт”-ийн Д.Грийд очжээ.

» ХӨЛБӨМБӨГ

“Манчестер Юнайтед” клуб “Реал”-ын довтлогч А.Моратаг авахаар 70 сая евро санал болгосон гэдгийг RT мэдээллээ. Гэхдээ испаничууд залуу довтлогчоо 80-90 саяд зарах бодолтой байгаа гэнэ. Мората өнгөрсөн улиралд “Реал”-ын төлөө 43 тоглолтод оролцождоо 20 гоол хийсэн юм.

» ХОККЕЙ

Канадын К.Крейн гэх хоккейч өсвөрийн лигийн нэгэн тоглолтын үеэр шүүгчийг цохисныхоо төлөө 30 хоног шоронд хоригдохоор болжээ. Toronto Sun мэдээлж буйгаар энэ явдал гуравдугаар сарын 26-нд болсон гэнэ. Тэрхүү тоглолтын үеэр нийтийг хамарсан зодоон болоход шүүгч салгахаар очсон байна. Гэтэл Крейн шүүгчийн нүүр рүү хэд хэдэн удаа цохиод авчээ. Үндэсний хоккейн лиг 2017-2018 оны улирлын шилдэг тоглогчийн шагнал нэр дэвшиж буй хүмүүсээ зарлалаа. Энэхүү шагналын төлөө “Коламбус”-ын С.Бобровский, “Чикаго”-гийн П.Кейн, “Питтсбург”-ийн С.Кросби, “Торонто”-гийн О.Мэттьюс болон “Эдмонтон”-ы залуу довтлогч К.Макдэвид нар өрсөлдөхөөр болоод байна. Улирлын шилдгүүдийг долдугаар сарын 12-нд болох ёслолын үеэр тодруулна.

Invitation for Bids

Date: 27 June 2017
Loan No. and Title: 3098-MON-Ulaanbaatar Urban Services and Ger Areas Development Investment Program: Tranche 1
Contract No. and Title: BRDH14: Construction of Roads, Heating Network and Associated Infrastructure in Bayankhoshuu Sub-Centre (Phase 2)
Deadline for Submission of Bids: 18 July 2017 (11:00 AM / Local Time)

- The Mongolia has received financing from the Asian Development Bank (ADB) toward the cost of Ulaanbaatar Urban Services and Ger Areas Development Investment Program: Tranche 1. Part of this financing will be used for payments under the contract named above. Bidding is open to Bidders from eligible source countries of ADB.
- The Municipality of Ulaanbaatar (“the Employer”) invites sealed bids from eligible Bidders for the Construction of Roads, Heating Network and Associated Infrastructure in Bayankhoshuu Sub-Centre (Phase 2) (“the Works”) that generally include construction of approximately:

| Bid No. | Title | Description of Works |
|---------|---|--|
| BRDH14 | Construction of Roads, Heating Network and Associated Infrastructure in Bayankhoshuu Sub-Centre (Phase 2) | <ul style="list-style-type: none"> Roads and drainage of 3.6 km; Street lighting of 7.5 km; Water supply network of 2 km; Sewerage network of 4.6 km; Heating distribution network of 2.4 km and Associated civil works. <p>Note: Sewerage and water supply pipes to be installed under this contract and will be purchased under separate procurement of goods.</p> |

- International competitive bidding will be conducted in accordance with ADB’s Single-stage One-envelope international competitive bidding procedure and is open to all Bidders from eligible countries as described in the Bidding Document.
- To be qualified for the contract package, bidders should as a minimum meet the following requirements:
 - Experience in Key Activities related to: (i) Construction of similar urban asphalt pavement minor arterial or collector road with total length of 3 km or longer, including filling of earthwork (6,000 m³/month), improved gravel or graded crushed stone base or sub-base (2,200 m³/month), and asphalt concrete mixed and placed (800 m³/month), (ii) Installation of water and sewerage networks with length of 5 km or longer, and (iii) Construction and installation of Heating networks with substations with length of 5 km or longer;
 - Minimum average annual turnover of US\$ 6.7 million calculated as total certified payments received for contracts in progress or completed, within the last three (3) years (2014, 2015 and 2016);
 - The Bidder must demonstrate that its financial resources defined in FIN - 3, less its financial obligations for its current contract commitments defined in FIN-4, meet or exceed the total requirement for the Subject Contract of US\$ 1.0 million (details are as stated in the Bidding document Section III, 2.3.3 Financial Resources);
 - Participation in at least one contract that has been successfully or substantially completed within the

- last five (5) years (2012, 2013, 2014, 2015 and 2016) and that is similar to the proposed civil works, where the value of the Bidder’s participation exceeds US\$ 5.3 million.
- For complete eligibility and qualification requirements refer to the bidding documents.
- To obtain further information and inspect the Bidding Documents, Bidders should contact the following address during working hours (excluding Saturdays, Sundays, and Holidays):

E.Bolormaa, Director of Procurement Agency of the Capital City
 Ulaanbaatar City Administrative Building-4
 Chingeltei District, Ikh toiruu-15
 Floor 10, Room No. 1002
 Ulaanbaatar, 15000
 Mongolia
 Telephone: +976 75757810
 Fax number: +976 75757809
 E-mail address: contact@ub-procurement.mn

Procurement Agency of the Capital City,
 Address: Ulaanbaatar city Administrative Building-4, Chingeltei District, Ikh toiruu-15
 Email: contact@ub-procurement.mn

| For foreign transfers: | For local transfers: |
|--|--|
| Account Name: Ministry of Finance of Mongolia 100200051015 Bank Account No: 340101868003 Bank Name: State Bank of Mongolia, Ulaanbaatar, Mongolia, SWIFT Code: STBMMNUB Correspondent bank: China Construction Bank, New York Branch SWIFT Code: PCBCUS33 Account No (USD): 675201295560 | Bank Name: Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар Bank Address: Нийслэлийн төрийн сан Bank Account (MNT): 100200051015 |

- Please note that Bidding Documents are issued in hard copies. Interested Bidders that purchase a hard copy may also request a copy to be provided by Email. In the event of any inconsistency between the hard and soft copies, the hard copy will prevail.
- Deliver your bid
 - to the address above (para 5)
 - on or before the deadline: 11:00 AM / Local Time on 18 July 2017
 - together with a Bid Security as described in the Bidding Document.
- Bids will be opened at 11:00 AM / Local Time on 18 July 2017 in the presence of Bidders’ representatives who choose to attend.
- When comparing Bids, ADB’s Domestic Preference Scheme will not be applied.

Амьдралын хэв маяг

Нэг километр зайд дугуй унахад эрүүл мэндийн даатгалаас 18 цент хэмнэдэг

Б.Баярмаа
@bayarmaaZGM

Саяас дээш хүнтэй метро-политан хотын иргэдийн цагийг бардаг “дайсан” нь замын түгжрэл. Харин Скандинавын орнууд бол дугуйчдын хувьд эрх чөлөөгөө эдэлдэг “диваажин”. Эдгээр орны иргэдийн 30-аас дээш хувь нь дугуй унадаг учраас нийгмийн асар олон асуудлаас хол амьдардаг. Замын түгжрэл, дуу чимээний болон агаарын бохирдол зэрэг үгийг



Дугуйчдад ээлтэй хотын сайн туршлага

“мартсан” иргэд нь нийгмийн стресс бага өртдөг учраас Дани, Нидерланд, Швед зэрэг орон аз жаргалын индексээр ямагт дээгүүрт бичигдэж иржээ.

Дэлхийд жилд дунджаар 50 сая автомашин үйлдвэрээс гардаг бол түүнээс хоёр дахин их шинэхэн дугуй эрүүл мэндээ анхаардаг хүмүүс худалдан авч байна. Үүний ихэнх хувийг эзэлдэг Скандинавын орнуудын иргэдийн хувьд дугуй амьдралынх нь салшгүй хэсэг болсон түүх 100 гаруй жилийн өмнөөс улбаатай. 1880-аад онд АНУ, Англид дугуйн үйлдвэрлэл цэцэглэж, Европ тив даяар дугуйн соёл нэгэн зэрэг түгсэн. Эхлээд залуучуудын дундаа моод байсан бол сүүлдээ өдөр тутмын амьдралынх нь нэг хэсэг болсон юм. Тухайлбал хүн амынх нь 30 гаруй хувь нь дугуйгаар ажил, хичээлдээ явдаг Дани улсын хувьд 1892 онд хамгийн анхны дугуйн замаа барьжээ. Тус улсын нийслэл Копенгаген өдгөө дугуйчдад ээлтэй хот гэдгээрээ танигдаад буй.

Копенгаген хотын иргэдийн 56 хувь нь ажил, хичээлдээ

дугуйгаар явдаг. Дугуйчид өдөрт нийт 1.2 сая километр зам туулдаг гэсэн сонирхолтой тоо бий. Харин насанд хүрэгчдийн 30 хувь нь дугуйг өдөр тутмын хэрэглээ болгожээ.

Эндхийн нэг хүн нэг километр зайд дугуй унахад эрүүл мэндийн даатгалаас 18 цент хэмнэдэг. Харин хотынхон эмнэлгийн үйлчилгээнд зориулах зардлаасаа жилд 91 сая ам.доллар хэмнэдэг гэсэн тооцоо гарчээ. Өдгөө тус хотод дугуй үйлдвэрлэдэг 20 гаруй компани, тэдгээрийг борлуулдаг 200 гаруй дэлгүүр бий. Эдгээр нь 650 ажлын байрыг хадгалж, 222 сая ам.долларын орлого олдог байна.

Энэ хотод 1895 онд 2500 дугуй байсан бол 17 жилийн дараа 80 мянга болон өсчээ. Хотын удирдлагууд Дэлхийн II дайн эхэлсэн 1939 оноос өмнө гэхэд бүх замыг дугуйн хэсэгтэй болгоод байв. Дайны үед шатахуун хомс байсан учраас иргэд автомашинаас хоёр дугуйг илүүд үздэг болсон аж. Харин дайны дараа Данийн Засгийн газраас шатахуунаа нөөцлөхийн тулд ням гарагийг

автомашингүй өдөр болгон зарласан нь үр дүнгээ өгчээ.

Гэхдээ Данид дугуйчид нэмэгдэх тусам тэдний осолд өртөх тоо ч мөн өсөх болжээ. Замын ослын тоо 1986 онд улсын хэмжээнд 14 мянгад хүрч, үүний 60-аас дээш хувийг дугуйчид, явган зорчигчид эзэлж байв. Тиймээс Засгийн газар нь дөрвөн жилийн дотор энэ хэмжээг 40 хувиар бууруулах зорилт тавьжээ. Мөн олон нийтийн байгууллагууд нэгдэж “Цагаан шугам” нэртэй аян өрнүүлсэн. Дугуйчид ослоос болж амиа алдсан замуудыг цагаан өнгөөр будаж, дугуйн замаа илүү аюулгүй болгохыг шаардсан аж. Аяны үр дүнд 2000 он гэхэд осолд өртөгсдийн тоо 9000 болж, үүнд эзлэх дугуйчдын тоо 10 хувьд хүрсэн байна. Энэ тоо өнөөг хүртэл бага багаар буурсаар байгаа юм.

Дугуйчдын “диваажин” гэгддэг Дани улсын хүн амын тоо 5.7 сая буюу манай улсынхаас бараг хоёр дахин их. Энэ оны эхний таван сарын байдлаар тус улсад 716 хүн замын осолд өртөж, 11 хүн нас барсан бол манай улсад 644 хүн осолд орж, 44 хүн үүний

улмаас амиа алджээ.

Данийн эрх баригчид хууль эрх зүйн орчноо шинэчилж, арван жил тутамд дугуйгаар зорчих орчныг сайжруулах талаар томоохон хэмжээний төлөвлөгөө боловсруулдаг болсон нь өдгөө ч хэрэгжиж буй. Тухайлбал, хотын захиргаанаас жил бүр осол гарах магадлал өндөр замын 20 уулзварыг засна гэсэн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлдэг. Мөн голын эрэг дамнасан дугуйн гүүрэн зам цөөнгүйг барьжээ.

Дугуйн хэрэглээ ихтэй орнуудад зогсоол толгойн өвчин болжээ

Гэхдээ Копенгагены дугуйчдад ээлтэй хотуудыг тэргүүлэх гэсэн амбицад цөөнгүй саад учирч байна. Өнгөрсөн жил хотод дугуй хулгайлсан 18 мянган хэрэг гарсан. Мөн шуудан хүргэгч, цагдаа гээд

төрийн бүхий л үйлчилгээг хоёр дугуйгаар хүргэдэг тул зогсоол толгойны өвчин болжээ.

Хотын иргэд амралтын өдрүүдэд галт тэрэгний буудал дээр дугуйгаа тавьдаг ч өдөр ирэх тусам зай нь хүрлцэхгүй болж байна. Учир нь тус хотод жилд 12 мянган хүн шинээр ирж суурьшдаг бөгөөд тэдний найман мянга нь дугуйчдын эгнээнд элсдэг. Дээр нь хотыг үзэхээр ирсэн жуулчдын тал хувь нь дугуйгаар аялдаг байна.

Энэ бэрхшээл дугуйн хэрэглээ гэрлийн хурдаар өсч буй АНУ, БНХАУ-д ч мөн тулгарч буй. Тиймээс хотууд дугуйн зогсоолыг шийдэх шилдэг санааны төлөө уралдаж байна. Тухайлбал Нидерландын Гронинген хотод галт тэрэгний буудлын газар доорх хонгилд 10 мянган дугуйн зогсоол байгуулсан. Энэ нь өдөр, шөнийн харуултай учраас хулгайн тоог эрс бууруулна гэж үзэж байна. Мөн тус улсын Ультрич хотын төв талбайд дөрвөн давхар зогсоолыг 4300 дугуй багтаахаар байгуулсан бол хотын захад 12 мянган дугуйн багтаамжтай олон давхар зогсоол нээжээ. [ЗГМ]

зөвлөгөө

Дуулга эрсдлийг 80 хувиар бууруулдаг

Дугуй эрүүл мэндэд олон талын ашигтай ч биед тохироогүй, техникийн бүрэн байдал хангаагүй бол эрсдэлтэй. Гэмтэж, бэртэхээс хамгаалах гол жор нь хамгаалалтын дуулга. Дуулгаа тогтмол өмсөж хэвшвэл толгойгоо гэмтээх эрсдэл 80 хувиар буурдаг юм байна. Гэхдээ дуулга толгойн хэмжээнд яг таарсан байх ёстой. Эс бөгөөс гэмтлийг хоёр дахин нэмдэг юм байна. Үүнээс гадна дуулга өмсөхдөө дух руугаа дарж, оосрыг нь сайтар бэхлээрэй.

Мөн шинэ дугуй худалдан авах гэж буй бол өөрийн өндөрт тохирсон эсэхийг нэн түрүүнд анхаараарай. Дугуйны жолооны хүрд нь суудлынхаа түвшнээс 2-3 см намхан байх стандарт бий. Засмал замын дугуйны дээд нугас болон таны гуя орчмын хооронд 3-5 см-ийн зөрүү байвал тохиромжтой гэж үздэг.

Харин уулын дугуйнд энэ хэмжээ таван см байх ёстой. Дугуйг хөлийнхөө завсар хавчуулсан байрлалтай зогсож дээрх уртуудыг хэмжинэ. [ЗГМ]

Дугуй унах алтан дүрмүүд

Уул өөд өгсөж орой дээр нь гарсны дараа хөлөө огт жийлгүй, сул тавин уруулдаг дугуйчид цөөнгүй. Гэтэл энэ нь эрүүл мэндэд сайнгүй. Дугуйгаар өгсөж байх үед хөлийн булчинд сүүн хүчил бөөгнөрсөн байдаг. Уулнаас уруудахдаа сулхан ч гэсэн хамаагүй жийж байж тэр хүчлийг тарааж, булчингийн үрвээсэл үүсэхээс сэргийлдэг юм байна.

Мөн гар тоормос хэрэглэж, тулгамдсан үед хоёр тормосоо зэрэг идэвхжүүлж сураарай. Хэрэв дугуйны дөрөө арзгар хээтэй, дээрээ давхар бэхлэгтэй бол хурдан жийхэд хялбар болдог. Түүнчлэн хүнд араан дээр удаан явахдаа татгалзах хэрэгтэй. Өвдгөндөө хэт ачаалал өгөхгүйн тулд үе үе хөнгөн араан дээрээ тохируулж явна. Нэг минутад 60-80 удаа хөлөөрөө жийх нь дундаж хэмжээнд тооцогддог. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2017 оны 06-р сарын 28-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр:

Нисгэгч, инженерийн дүрэмт хувцас бэлтгэн нийлүүлэх тендер

Тендер шалгаруулалтын дугаар: **29/2017-М**

МИАТ ТӨХК эрх бүхий тендер оролцогчдоос Нисгэгч, инженерийн дүрэмт хувцас бэлтгэн нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50.000** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 2015, 2016 онуудын нийлбэр нь санал болгож буй тендерийн үнийн дүнгээс багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Судалсан зээлийн хэмжээ санал болгож буй үнийн дүнтэй ижил хэмжээний зээл олгох боломжтой байх**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **2015, 2016 он**

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын туршлагын мэдээлэл ирүүлэх: **2015, 2016 онуудын ижил төстэй бараа нийлүүлж байсан гэрээний хуулбар**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **шаардлагагүй**

Тендерийн хамт Багц 1: 4 800 000 төгрөг

Багц 2: 2 072 100 төгрөг

Багц 3: 3 333 400 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 07-р сарын 28-ны өдрийн 15 цаг 30 минутаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 07-р сарын 28-ны өдрийн, 16 цагт** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй,

Дотоодын давуу эрх тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Буянт-Ухаа, МИАТ ХК-ийн төв байр, Хангамж, үйлчилгээний хэлтэс, 103 тоот өрөө, мэргэжилтэн Б.Мөнгөнчимэг Шуудангийн дугаар: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Буянт-Ухаа-45, 17120 МИАТ ХК
Утас: 70049860, Факс: 70049919

Имэйл: mungunchimeg.b@miat.com

Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

Invitation to Bid Form to supply uniforms for pilots and engineers

June 28, 2017

Re: **Invitation to Submit Bid for Supply of Uniforms for Pilots and Engineers of MIAT Mongolian Airlines JSC**

MIAT Mongolian Airlines JSC is writing to you today to inform you that you are hereby invited to submit a sealed bid as the general contractor on a contract for the supply of Uniforms for Pilots and Engineers for MIAT Mongolian Airlines JSC.

Copies of the bid documents (if necessary, additional copies) are available at our office at the above listed company upon a written request for the purchase at 50.000MNT or other equal freely convertible currencies with irrevocable conditions. This bid is valid for 45 days from the date of opening.

Bidders must meet the following financial and experience conditions and requirements:

- Sales amount: total sum of 2015 and 2016 sales must be not less than bidding amount
- Faster convertible assets and available loan amount: must be eligible for the loan amount equal to offered bidding amount
- Numbers of audited financial statements to deliver: 2015 and 2016 financial statements
- Information on similar works and service experiences for the recent two years: a copy of contracts to supply
- Whether it is necessary to deliver a copy of special licenses: not necessary

Bidders shall deliver the bidding guarantee equal to the sum of:

Pack 1 together with Bid: 4 800 000MNT

Pack 2 together with Bid: 2 072 100MNT

Pack 3 together with Bid: 3 333 400MNT

Bidding documents shall be delivered to the following address before 15.30 on July 28, 2017. The bidding shall be opened at 16.00 on July 28, 2017 with the participation and attendance of bidders.

Foreign bidders are eligible for bidding activities and domestic bidders shall not enjoy a privilege. Interested bidders may obtain bidding documents and other information from the address below:

MIAT Mongolian Airlines Head Office,
17120 Buyant-Ukhaa 45, Khan-Uul district, 10th khoroo, Ulaanbaatar, Mongolia Procurement and Service Department, Room 103,
Attn: Mungunchimeg B.
Postal address: MIAT Mongolian Airlines,
17120 Buyant-Ukhaa 45, Khan-Uul district, 10th khoroo, Ulaanbaatar, Mongolia
Tel: 976-70049860, Fax: 976-70049919
E-mail: mungunchimeg.b@miat.com

Лавлах

СЭРЭМЖЛҮҮЛЭГ Энэ сарыг дуустал хална

Ө.Дэнсмаа
ЗГМ

Зургадугаар сарын 27-н буюу өчигдөр нийт нутгаар 30 градусаас дээш халжээ. Тухайлбал, баруун болон төвийн бүс нутгаар 30 градус хүрч, зүүн болон говийн аймгуудаар түүнээс дээш халсан байна. Тэр дундаа Хэнтий аймагт +38 градус хүрчээ. Цаг уур, орчны шинжилгээний газраас авсан мэдээллээр энэ сар дуустал нийт нутгаар хэт халуун үргэлжилнэ. Харин долдугаар сарын 2, 3-наас халалт буурах төлөвтэй байна. [ЗГМ]

Гол усны осол нэмэгдлээ

Ойрын өдрүүдэд ихэнх нутгаар цаг агаар 30-35 градус хүртэл халж, бүгчим халуун байгаа тул иргэд гол ус бараадан амарч зугаалах нь ихэссэн. Ингэхдээ санамсар болгоомжгүйн улмаас усанд осолдох, амь насаа алдах тохиолдол нэмэгдэх хандлагатай байгааг ОБЕГ-аас анхаарууллаа. Тодруулбал он гарсаар өнөөдрийн байдлаар 12 аймгийн 26 сум, нийслэлийн дөрвөн дүүрэгт нийт 38 удаагийн усны осол гарч, 44 хүн амь насаа алдсан байна. Хэт халуун өдрүүд үргэлжилж байгаатай холбогдуулан иргэдийг чөлөөт цагаараа гол, усны ойролцоо амарч зугаалахдаа анхаарал сэрэмжтэй байхыг санууллаа. [ЗГМ]

Зөвлөгөө Наршилт, хордлогоос сэргийлэх арга

Үндэсний их баяр наадмын үеэр хамгийн их борлуулалттай хүнсний бүтээгдхүүн бол түргэн хоол, төрөл бүрийн ундаа ус, жимсний шүүс байдаг билээ. Гэтэл бидний худалдан авч буй ундаа, жимсний шүүс нь цэвэр байгалийн гаралтай бүтээгдэхүүн биш юм. Тухайлбал, жимсний шүүс, ундаа нь их хэмжээний сахараас гадна олон төрлийн амт үнэр оруулагч агуулдаг. Түүнчлэн наранд удаан байсан ундаа, жүүс хордлого авах бас нэг шалтгаан болдог байна. Харин хярам, ширгээсэн ус, хүйтэн цай зэрэг нь хордлогоос урьдчилан сэргийлэхээс гадна амны цангааг тайлдаг. Баяр наадмын үеэр аль болох гэртээ бэлдсэн хярам, цай, ширгээсэн ус уухыг эмч мэргэжилтнүүд зөвлөж байна. [ЗГМ]

Танин мэдэхүй Аялалд хэрэгтэй дөрвөн аппликейшн

Mars me-Хүссэн газраа олж харахаас гадна зай хэмжих боломжтой. Интернэтгүй орчинд ашиглаж болно.
Mobile passport-Гадаад паспорт, цахим үнэмлэх эрүүл мэндийн дэвтэр зэрэг яаралтай хэрэг болох зүйлсээ хувилаад хадгалж авах боломжтой.
Weather pro-Дэлхийн аль ч улсын цаг агаарын мэдээг хүлээн авах боломжтой.
Travel safe-Жуулчдад хамгийн их тулгардаг асуудал бол улс бүрийн хууль байдаг. Хууль болон хориглох зүйлсийн жагсаалтыг эндээс харж болно. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

| | MNB | Bloomberg | Боловсрол | Монгол ТВ |
|--------------|---|--|--|--|
| 08.00 | 09.00 "Хөдөөгийн баясгалан" Монголын уран сайхны кино | 07.30 "Сайн уу дэлхий" нэвтрүүлэг | 09.20 "Cook Club" хоолны шоу нэвтрүүлэг | 09.30 Тог тог тог /season-4/ 51 дүгээр хэсэг |
| 12.00 | 12.20 "Өв эрдэнэ" нэвтрүүлэг | 11.30 "Ажил хэрэгч өглөө" нэвтрүүлэг | 11.15 "Мердокийн тайлагдашгүй нууцууд" ОАК | 13.00 "Тэр" хөрөг нэвтрүүлэг |
| 14.00 | 13.20 "Цэлмэг" өдрийн хөтөлбөр | 16.00 "Эзэнт гүрнийг босгосон нь" нэвтрүүлэг | 14.10 "Зөв үнийг таа" шоу нэвтрүүлэг | 15.00 Галилео 10 дугаар хэсэг |
| 18.00 | 16.25 "Урлаг" теле сэтгүүл | 17.00 "Bloomberg Surveillance" | 18.55 Гранд мед үзүүлж байна | 17.30 Спортын шинжлэх ухаан 8 дугаар хэсэг |
| 20.00 | 21.10 "Нээлттэй хэлэлцүүлэг" / шууд/ | 20.00 "Блум-бергийн ярилцах цаг" нэвтрүүлэг | 20.50 "80 саяын уналт" асуулт хариултын шоу нэвтрүүлэг | 21.00 "Миний найзууд" СОАК 2 дугаар анги |
| 22.00 | 22.15 "Хүргэн хүү" Монголын уран сайхны кино | 22.30 "Алсын хараа" нэвтрүүлэг | 22.00 "Көсем" ОАК 43-р анги | 00.00 "Декстер" ОАК /season-1/ 5 дугаар анги |

ОНЦЛОХ ҮЗВЭР

Хязгааргүйд тэмүүл



Зураач Д.Соёлмаагийн "Дүүлэн" уран зургийн үзэсгэлэн "Бум" арт галерейд долдугаар сарын 3-н хүртэл гарч байна. Тус үзэсгэлэнд нийт 20 орчим бүтээл дэлгэсэн бөгөөд ихэвчлэн бурхны шашны сэдэвт зургууд байгаа юм. Зураач Д.Соёлмаа "Бурхан шашин бол миний хамгийн дуртай сэдэв. Тиймээс би өөрийн дотоод төсөөлөл мэдрэмжээ бурхнаар илэрхийлдэг" гэж хэлсэн юм. Бурхад болон монгол ахуй хоёрыг холбож уран бүтээлээ туурвидаг тэрбээр АНУ, Канад, БНСУ зэрэг 10 гаруй улсад үзэсгэлэнгээ гаргаж байжээ. Тэрбээр "дүүлэн" хэмээх нэртэй зургийнхаа нэрээр үзэсгэлэнгээ нэрлэсэн байна. Тус зураг нь хязгааргүйд тэмүүлэх хүслийг илэрхийлсэн аж. Монгол ахуй, бурхны шашны хослолыг харахыг хүсвэл тус үзэсгэлэнг зориорой. [ЗГМ]

ҮЗВЭР

III сөв

Монгол Улс, Итали улстай соёл урлагийн харилцаа холбоогоо өргөжүүлэх зорилгоор Филармони, ГХЯ, Хилийн чанад дахь монголчуудын зөвлөл хамтран "Барокко: Итали болон Европ" (Grand Galá: Barocco, Italy & Europe) гала тоглолтыг зохион байгуулах гэж байна. Тоглолт пүрэв гарагийн 18.00 цагт болно.

ЧИНГИС ХААНЫ МОРЬТ ХӨШӨӨТ ЦОГЦОЛБОР

Монгол угсаатны түүхийн үнэ цэнийг орчин үеийн хөгжимтэй хослуулан сурталчлах зорилготой Hunnu Music Festival арга хэмжээг баасан гарагийн 12.00 цагт зохион байгуулна. Энэ жилийн наадамд 3-5 DJ болон нийт 18 цагийн шоу хөтөлбөрийг хүргэх аж.

ҮНДЭСНИЙ СОЁЛ АМРАЛТЫН ХҮРЭЭЛЭН

Продюсер Б.Ангирмаа шавь нартайгаа хамтран "Ангирмаатай үдэш" тоглолтоо энэ сарын 30-ны 19.00 цагт толилуулна. Үндэсний соёл амралтын хүрээлэн Шөнийн парк хөтөлбөрөө зургадугаар сарын 30-н, долдугаар сарын 1-нд зохион байгуулна. Найз нөхөд, гэр бүлийн хамт парк дээр тоглонгоо олон төрлийн сонирхолтой үзүүлбэр үзэх боломжтой.

МОНГОЛ ШИЛТГЭЭН

Монгол шилтгээн цогцолбороос зохион байгуулж буй Bonfire party энэ сарын 30-нд болно. Их хотын 200 залуус зориулсан галын наадмын цогц арга хэмжээг анх удаа хийж буй бөгөөд зориулалтын талбайд болох аж.

ЗУРХАЙ




Билгийн тооллын 5

Зуны дунд улаан морь сарын гурван хөх мэнгэтэй улаан нохой өдөр
Үс засуулбал: Эд, мал арвижна.
Наран ургах, шингэх: 04.58-20.50
Барилдлага: Үхэх
Шүтэн барилдлага: Авахуй
Суудал: Мод

Аргын тооллын зургадугаар сарын 28. Буд гараг. Билгийн тооллын 5, Их морь одтой, улаан нохой өдөр.

Өдрийн наран 04.58 цагт мандан, 20.50 цагт жаргана. Тухайн өдөр бар жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгус муулах, лус тахих, хүүхэд үрчлэн авах, гэр, байшингийн суурь тавихад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийх, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Модон хохимой, тэрсүүд давхцсан өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвижна.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



11. Агаарт хуран цугларсан усны уур
 12. Өртөг
 13. Монголын нэгэн ястан
 14. Хүний хүндэтгэл
 15. Хөрөнгө
 16. Улс
 17. Адууны нэг зүйл зүсэл өнгө улаан бөгөөд холоос үзэхэд бараан мэт харагдана.

Хөндлөнгөөр:

2. Завхан аймгийн сум
 6. Дөт, хол биш

7. Юмны ач тус болох сайны хувь
 8. Ихээхэн урсгал ус
 9. барааны бодит өртөг
 10. Толгой, тэргүүн
 14. Дээл хувцасны уужим урт

18. ... саар
 19. Алдар хүнд
 20. Оольд баруул болгож хийсэн иш
 21. Загас, мэлхийний доторх цагаан өвх
 22. Их хэмжээтэй урсгал ус

Өмнөх дугаарын хариу /06.27

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Н | Т | В | О | Л | О | Б |
| Ү | | | Д | | | Э |
| Х | А | Н | Х | О | Н | Г |
| Т | Ө | | Н | О | | С |
| | | Х | А | Ч | И | Р |
| А | Ө | | И | О | | А |
| Б | А | Д | А | М | Д | О |
| Б | | | | Э | | И |
| А | Р | Ц | | Г | З | О |

ЗГМ: СҮДОКУ


| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 4 | 2 | | 3 | | | 7 |
| | | | | | | 6 | 2 |
| 5 | 7 | | | 8 | | | |
| 6 | | 3 | 4 | | | | 9 |
| 4 | | | 1 | 7 | | | |
| | | | 9 | 6 | | 4 | |
| | 7 | | | 4 | | | 8 |
| | | | | | 1 | | 5 |
| 1 | 9 | 7 | | 5 | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | 6 | 1 | 8 | 5 | 7 | 3 | 4 | 2 |
| 5 | 2 | 8 | 9 | 3 | 4 | 7 | 1 | 6 |
| 4 | 7 | 3 | 6 | 1 | 2 | 5 | 8 | 9 |
| 1 | 9 | 5 | 3 | 2 | 6 | 8 | 7 | 4 |
| 7 | 3 | 4 | 1 | 9 | 8 | 2 | 6 | 5 |
| 2 | 8 | 6 | 7 | 4 | 5 | 9 | 3 | 1 |
| 3 | 5 | 7 | 2 | 6 | 1 | 4 | 9 | 8 |
| 6 | 4 | 9 | 5 | 8 | 3 | 1 | 2 | 7 |
| 8 | 1 | 2 | 4 | 7 | 9 | 6 | 5 | 3 |

(Өмнөх дугаарын хариу)

ЦАГ АГААР

| УЛААНБААТАР | VI.28 | VI.29 | VI.30 | VI.1 | VII.2 |
|-------------|------------------------|------------------------|-----------------------|-----------------------|------------------------|
| Уүлшинэ | 33° 18' / 10 м/с 8 м/с | 31° 18' / 10 м/с 8 м/с | 32° 16' / 8 м/с 6 м/с | 34° 18' / 8 м/с 6 м/с | 29° 18' / 10 м/с 6 м/с |
| | Уүлшинэ | Бага зэргийн бороотой | Уүлшинэ | Уүлшинэ | Бага зэргийн бороотой |



[ЗГМ]

"ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ" СОНИНЫ ОНЛАЙН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.

"ZGM-FINANCIAL TIMES-NYT" ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙГ НЭГ ДОРООС ЗАХИАЛГЫН ҮНЭ УЛИРАЛД 5000 ТӨГРӨГ

99903581, 70103131

УНШИГЧ ТА МАНАЙ СОНИНЫ НИЙТЛЭЛ, МЭДЭЭ, СУРВАЛЖЛАГАТАЙ ХОЛБООТОЙ САНАЛ ХҮСЭЛТЭЭ

OPED@ZASAG.CO

ХАЯГААР ИРҮҮЛНЭ ҮҮ.

ЗГМ: КОМИКС

Mr. Баагийгийн ПЯН...

НОВАДИС COMICS [ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ]

АНДУУДАА УРАГШАА Ч ЮМ УУ, ХОЙШОО Ч ЮМ УУ, ЖООХОН ЗАЙ ГАРГАЧИХ.

PLAY TIME

ГАЛТ ТЭЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

| | | |
|---------------|-------|-------|
| Бээжин-Москва | 07.45 | 14.28 |
| Москва-Бээжин | 21.35 | 14.30 |
| УБ-Москва | 13.50 | 14.28 |
| Москва-УБ | 21.35 | 07.30 |
| Эрэн-УБ | 18.00 | 11.15 |
| УБ-Эрэн | 20.00 | 10.25 |
| УБ-Бээжин | 07.15 | 14.04 |
| Хөх хот-УБ | 22.50 | 11.15 |
| УБ-Хөх хот | 20.00 | 20.49 |
| УБ-Эрхүү | 21.10 | 02.40 |
| Эрхүү-УБ | 15.35 | 06.20 |

НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

| | | |
|---------------|-------|---------|
| УБ-Бээжин | 06.10 | 08.25 |
| УБ-Токио | 07.55 | 13.40 |
| УБ-Сөүл | 08.45 | 12.50 |
| УБ-Москва | 09.15 | 10.55 |
| Бээжин-УБ | 09.30 | 12.00 |
| Москва-Берлин | 11.55 | 13.35 |
| Сөүл-УБ | 14.20 | 16.50 |
| Токио-УБ | 14.40 | 19.10 |
| Берлин-Москва | 14.55 | 18.20 |
| Москва-УБ | 19.25 | 06:35+1 |
| УБ-Ханбумбат | 20.00 | 21.10 |
| Ханбумбат-УБ | 22.00 | 23.05 |

Эрүүлийг хамгаалах хууль 22 сая хүнийг даатгалгүй болгоно

Конгрессын төсвийн хорооны дүгнэлтийг Цагаан ордон төдийлэн хэргэсэхгүй байгаа. > 10

Европын банкууд блокчэйн арилжааны платформ ажиллуулна

XVI зуунаас үүсэлтэй худалдааны санхүүгийн хуучин тогтолцоог шинэ технологи түүх болгоно. > 10

Ши даргын эриний бэлгэдэл - Хятадын өндөр хурдны галт тэрэг

Шинэ үеийн суман галт тэргэнд Ши Жиньпиний эринийг бэлгэдсэн нэр өглөө. > 10



Өмнөд Солонгосын протекционизмд шахалт үзүүлэв

Брайн Харрис

Өрнөдийн бизнесийнхэн Өмнөд Солонгосын шинэ Ерөнхийлөгчид протекционизмыг зөөлрүүлж, эдийн засгаа нээх тал дээр шахалт үзүүлж эхэлжээ. Ноён Мун Жаэ Ин энэ долоо хоногт АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамптай уулзахын өмнө энэ дарамт улам идэвхжиж байна. Америкийн тал хоёр улсын хоорондын худалдааны гол гэрээг эргэн

харах, тэр ч бүү хэл цуцлах асуудлыг сөхөж магадгүй хэмээн анхааруулсан. Өмнөд Солонгос бол экспортод тулгуурласан эдийн засагтай улс агаад ДНБ-ий 50 хувийг эзэлдэг. Худалдаа тасалдах буюу орчин муудвал Сөүлд хүнд цохилт болох нь дамжиггүй.

Гэвч өрнөдийн бизнесийнхэн болон дипломатууд 2011 онд Европын холбоотой, 2012 онд АНУ-тай байгуулсан

худалдааны гэрээний үзэл санааг үл харгалзан Сөүл тарифын бус хориг саад тавьсаар буйд сэтгэл дундуур байдгаа илэрхийлжээ. Өрнөдийн нэгэн дипломат “Чөлөөт худалдааны гэрээний үзэл санааг хэрэгжүүлэхгүй байна. Энэ бол бидний санаа зовох үндэслэл. Өмнөд Солонгос чөлөөт худалдаанд үл итгэн экспорт сайн, импорт муу хэмээн үзэж байгаа бололтой” гэжээ. Бизнесийн удирдагчид

Ерөнхийлөгч Мунд хандан худалдааны орчны зохицуулалтад өөрчлөлт хийхийг уриалсан юм.

Тухайлбал, “Зөвхөн Солонгосын стандарт” гэх шалгуураар олон улсын стандартаас ялгаатай журам тогтоож бараа, бүтээгдэхүүнд хаалт тавьдаг журмыг шүүмжлэв. Үүний экспорт сайн, импорт муу хэмээн үзэж байгаа бололтой” гэжээ. Бизнесийн удирдагчид

чиглэлд ажиллах ёстой. Энэ нь хоёр талын ашигтай. Үүнд зарим бүтээгдэхүүний үнийг бууруулах ба дэлхийтэй технологи, ноухаугаа солилцох боломж бүрдэнэ” хэмээн тайлбарлав. Америкийн худалдааны танхим мөн энэ байдлыг шүүмжлээд олон улсын стандартад нийцүүлэх, зохицуулалтын ил тод байдлыг сайжруулах ёстой гэжээ.

Өмнөд Солонгосын зохицуу-

лагчид хатуу журмаа эрүүл мэнд, аюулгүй байдал гэх мэт үндэслэлээр тайлбарладаг. Тэд түүнчлэн Хятад, АНУ-ын зүгээс ган ба төмөр эдлэлийн хувьд протекционист хандлага гаргадаг хэмээн буруутгаж буй. Ерөнхийлөгчийн хөх ордны төлөөлөгч манай сонинд ярихдаа “Одоо тус улсын худалдааны орчныг хэлэлцэх цаг биш. Шинэ засаг захиргаа ажлаа дөнгөж эхэлж байна” хэмээв.

Сөүл дэх Британийн Худалдааны танхимын төлөөлөгч Шон Блейкли шинэ Ерөнхийлөгч эдийн засгаа нээлттэй болохыг алхамууд хийж байгаа боловч цаашид либералчлах нь дотоод, гадаадын компаниудын аль алины ашиг сонирхолд нийцэхийг онцолжээ.



Энэтхэгийн татварын шинэчлэлийн өмнөх сандрал



Манай сонины сурвалжлагчийн олж авсан уриалгаас үзэхэд бизнесийн бүлгүүд хэд хэдэн өөрчлөлт санал болгож байгаа аж.

Үүнд компаниудаас сард гурван удаа мэдээлэл гаргаж өгөх шаардлагыг цөөрүүлснээр үйл явц удаашрахаас сэргийлж, татварыг түргэн төлөх боломж бүрдүүлнэ гэж үзжээ. Холбооны гэнэтийн арга хэмжээ авснаас бизнесийг хялбаршуулах Засгийн газрын бодлогод сөрөг нөлөө үзүүлнэ. Ийм урт хугацааны үр дагавартай шинэчлэлийг түргэн эхлүүлэх гэж юунд яарна вэ” гэсэн юм. Зарим хүн Энэтхэгийн бүх компанийг анх удаа цахимаар татварын мэдүүлгээ өгдөг болгох арга хэмжээ том бэрхшээл үүсгэнэ хэмээн болгоомжилдог. Татварын цахим платформыг эрхлэн ажиллуулах GST Network компанийн захирал Навин Кумар хангалттай цаг өгөөгүй учир програмын заримыг бүрэн туршиж амжаагүй байгааг мэдээлжээ.

Тэрбээр “Бид цагийн шахалтад орсон. Өдөрт 28 цаг ажиллаж байна” хэмээн Business



Аюулгүйн дэрний гэмтэл дампууралд хүргэлээ



Кана Инагаки

Японы Takata компанийн үйлдвэрлэсэн аюулгүйн дэр дэлбэрсний улмаас бүтээгдэхүүнээ татаж, 10 тэрбум ам.долларын нөхөн төлбөр олгох үүрэг хүлээсэн. Тус компани Япон, АНУ-д дампуурлаас хамгаалах хуульд хамрагдах хүсэлт гаргажээ. Үүний үр дүнд 84 жилийн түүхтэй, Японд жолоочийн анхны аюулгүй дэр үйлдвэрлэж эхэлсэн Takata-гийн үндсэн хөрөнгийг Key Safety Systems компани 1.6 тэрбумаар худалдан авах төлөвтэй байна. Америкийн энэ үйлдвэрлэгчийг Ningbo Joyson Electronic хэмээх Хятадын компани эзэмшдэг аж. Takata-гийн дампуурал Honda, Toyota, Volkswagen зэргийг оруулаад дэлхийн 13 авто үйлдвэрлэгчийг хэдэн сая машинаа эргүүлэн татах төвөгтэй нөхцөлд үлдэж байна. Эдний аюулгүйн дэр чийгшил ихтэй орчинд өөрөө дэлгэгддэг гэх асуудал 2008 онд илэрсэн. 2013 онд аюулгүйн түгшүүр

газар авч, Toyota, Honda, Nissan, Mazda компаниуд гурван сая гаруй машинаа татсан нь жолоочийн талын аюулгүйн дэрний согогтой холбоотой. Дэрний хий дүүргэгчийн хаалт буруу ажилласнаас наад зах нь 17 хүний амь эрсдэж, 100 гаруй хүн шархадсан гэсэн дүгнэлт гарсан юм. Үүнд 13 компанийн 100 гаруй маркийн автомашин хамрагдсанаас одоо дөнгөж гуравны нэгийг эргүүлэн татаад буй.

Хэрэглэгчид болон машин үйлдвэрлэгчид уг асуудлыг туршилтын үр дүнг хуурамчаар үйлдсэн хэмээн буруутгасан ба хэд хэдэн компани Takata-гийн бүтээгдэхүүнийг шинэ машинд тавихаа зогсоосон билээ. Энэ дуулиан компанийн санхүүд хүнд дарамт учруулав. Takata гуравдугаар сар хүртэлх санхүүгийн жилд 715 сая ам.долларын алдагдал хүлээсэн

ба гурав дахь жилдээ ашиггүй ажиллаж байна.

Дампуурлын үйл явцын дараа машиныг эргэн татах өртөгийг Takata гаргаж чадахгүйд хүрвэл машин үйлдвэрлэгчид эднийхийг дэмжих, эсэх нь тодорхойгүй. Нэгдүгээр сард тус компани хууран мэхэлсэн хэрэгт татагдаж, нэг тэрбум ам.долларын торгууль төлөхөөр болсон ба АНУ дахь гурван захирал нь шийтгэл хүлээжээ. Тус компанийн ирээдүйн талаар хэлэлцээ жил орчим үргэлжилж, үүсгэн байгуулагч гэр бүлийнхэн машин үйлдвэрлэгчидтэй шүүхээс гадуур тохиролцохыг илүүд үзсэн бололтой.

Хоёрдугаар сард Takata бие даасан гаднын шинжээчдийн зөвлөгөөний дагуу Key Safety Systems-г санхүүгийн дэмжигчээрээ сонгосноо зарласан. KSS-тэй гэрээ байгуулсны дагуу Хятадын хөрөнгө оруулалттай компани дуулианы бай болсон гэмтэлтэй хаалтаас бусад Takata-гийн үндсэн хөрөнгийг

худалдан авахаар шийдсэн аж. KSS-ийн захирал Жейсон Лу “Takata хэдийгээр дэлхий даяар аюулгүйн дэр эргүүлэн татах ажиллагааны дарамтыг амсаж байгаа ч эдний ажиллах хүчний ур чадвар, газар зүйн хүртээмж, жолооны хүрд, суудлын бүс болон бусад аюулгүйн бүтээгдэхүүн нь алга болчихоогүй байна” гэж мэдэгдсэн юм.

Токиод төвтэй Takata компани анх 1933 онд давууны үйлдвэрлэл эрхлэхээр байгуулагдсан юм. Эхлээд цэргийн парашют хийж байснаа суудлын даруулга, улмаар 1980-аад оноос аюулгүйн дэр үйлдвэрлэж эхэлсэн. 1980-аад оны сүүлээр эднийх хэд хэдэн томоохон худалдан авалт хийж, аюулгүйн дэр үйлдвэрлэгч дэлхийн гурван том компанийн нэг болж чадсан байна. Takata оргил үедээ жилийн 662 тэрбум иенийн орлоготой байснаас 37 хувийг нь аюулгүйн дэрний борлуулалт бүрдүүлж байв.



© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.



BBM©

хэмээн Цагаан ордон мэдэгдсэн юм.

Эрүүлийг хамгаалах хуулийг батлуулахын тулд Бүгд найрамдах намаас Сенатад сонгогдсон гишүүд “хавчиг жим”-ээр явахаас аргагүйд хүрч буй талаар ноён Трамп ням гарагт тайлбарлаж байв. Хуулийн шинэ төсөл сэтгэл зовоож байгаа талаар Невада мужаас сонгогдсон сенатор, аядуу үзэлт бүгд найрамдахч Дин Хэллер өгүүлсэн. Эсрэг байр суурьтай өөр нэг аядуу үзэлт бүгд найрамдахч, Мэн муж улсаас сонгогдсон сенатор Сьюзан Коллинс Конгрессын үндэсний хорооны дүн шинжилгээг судалж байж эцсийн шийдвэр гаргахаа мэдэгдсэн юм. Уг дүн шинжилгээний тайлан гарсны дараа хатагтай Коллинс хуулийн төслийг эсэргүүцэж буй Бүгд найрамдах намын харьяат зургаа дахь сенатор боллоо.

“Ерөнхийлөгч Трамп хайрлаад

Эрүүлийг хамгаалах хууль 22 сая хүнийг даатгалгүй болгоно

Деметри Севастопуло

Бүгд найрамдах намаас Сенатад оруулж буй, Obamacare-ийг орлох шинэ хууль хэрэгжих аваас эрүүл мэндийн даатгалгүй америкчуудын тоо 22 саяар нэмэгдэх талаар сүүлд хийсэн шинэ судалгаанд тайлбарлажээ.

Сенатад оруулж буй төслийг АНУ-ын Конгресс дахь нам бус байгууллага – Конгрессын төсвийн хороо судалж үзээд энэ тавдугаар сард Төлөөлөгчдийн танхим баталсан төсөлтэй ижил буюу 2026 он гэхэд даатгалгүй америкчуудыг 23 саяд хүргэх үр дагавартай гэсэн дүгнэлт гаргалаа.

Сенат хэлэлцэх төсөл нь

дээр дурдсан хугацаанд төсвийн алдагдлыг 321 тэрбум ам.доллараар бууруулж байгаа нь төлөөлөгчдийн танхимаар оруулсан төслийн 119 тэрбум ам.долларын хэмнэлттэй харьцуулахад хавьгүй их байгаа юм.

Барак Обамагийн 2010 онд баталсан Obamacare эрүүл мэндийн хуулийг цуцлуулахаар Цагаан ордон идэвхтэй шахалт үзүүлсээр өдий хүрлээ. Уг шахалт нь Дональд Трамп сонгуулийн кампанийн үеэр амласан амлалтаа биелүүлж, Зууван танхимд ажиллах болсон эхний таван сард байгуулж амжаагүй хууль зүйн томоохон алалтдаа бэлтгэж буйн илрэл юм.

Сенат дахь Бүгд найрамдах намын удирдагч Митч МакКоннел гишүүдээс авах санал хураалтыг долдугаар сарын 4-ний Тусгаар тогтнолын баяраас өмнө явуулах бодолтой. Гэхдээ тус нам ноёрхож буй Сенат дахь 52 бүгд найрамдах гишүүнээс хууль батлахад шаардлагатай 50-ийнх нь саналыг авч чадах эсэх нь эргэлзээтэй.

“Үр дүнгүй Obamacare хуулиас америкчуудыг ангижруулах шаардлагатай. Конгрессын төсвийн хороо шууд сайшаах хуулийн төслийг Сенат удахгүй батална. Энэхүү хуулийн ачаар Obamacare-аас шалтгаалсан илүү зардал багасаж, дундаж

ангийн татварын дарамт хөнгөрч, төсвийн алдагдал буурна” хэмээн ноён МакКоннел тайлбарлав.

Одоогийн арга хэмжээ Obamacare-ийг хөмөрч хаяхад хангалтгүй хэмээн шүүмжилдэг консерватив хэсэг, уг арга хэмжээ сонгогчдын саналыг алдах аюултай хэмээн болгоомжлогч аядуу байр суурьтай хэсгийн хооронд ухаалаг тэнцвэр бириулахаар Бүгд найрамдах намын удирдагч нар чармайж байна.

Уг арга хэмжээг санал нэгтгэж эсэргүүцэж буй Ардчилсан намын гишүүд Бүгд найрамдах намын арав гаруй эрэгтэй гишүүнтэй нууц тохиролцоо байгуулсан нь хуулийн төсөл

нийт Конгрессоор дамжсан хойно тодорхой болох юм.

Конгрессын төсвийн хорооны дүгнэлтийг төдийлэн хэрэгсэхгүй байгаа Цагаан ордон тус байгууллагын тооцоо зөрж ирсэн түүхтэйг анхааруулж чаддаггүй” хэмээн Цагаан ордон тайлбарласан. “Даатгалын нөхөн төлбөр, төсвийн алдагдлын болзошгүй хэмжээний талаар оновчтой тооцоо гаргаж ирсэн түүх нь дүн шинжилгээнд сохроор итгэх шаардлагагүй гэсэн дүгнэлт хийхэд хүргэлээ”

байх юмгүй гэж тайлбарлаад байсан эрүүлийг хамгаалах шинэ хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхим баталсан. Тэгвэл одоо Сенат дахь бүгд найрамдахчууд сэтгэлгүй хуулийн төсөл дэвшүүлээд” хэмээн Сенатад Эрнөд Виржин мужийн Ардчилсан намаас сонгогдсон гишүүн Жоэ Манчин тайлбарлав.

Шинэ төсөл нь “Баялгийг ажилчдын айл гэрээс маш баян хүмүүст бөөнөөр нь шилжүүлснээ өөр зүйлгүй эд болж” хэмээн 2016 оны Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас өрсөлдөж байсан, Вермонтын сенатор Берни Сандерс дүгнэв.



Европын банкууд блокчэйн арилжааны платформ ажиллуулна

Мартин Арнольд

Европ тивийн хамгийн том долоон банк хамтын хүчээр худалдааны санхүүжилтийг блокчэйн технологид шилжүүлж, жижиг бизнес эрхлэгч нарын хил дамнанс захиалгыг санхүүжүүлэх платформыг IBM-ын туслалцаатай байгуулах гэж байна.

Уг санаачилга нь худалдааны санхүүгийн салбарт блокчэйн технологи ирээдүйтэй хэмээн банкуудын удирдлага үзэж буйн илрэл боллоо. Анх bitcoin зэрэг шифрлэсэн дижитал валют хэлбэрээр үүссэн блокчэйн технологи эдүгээ эдийн засгийн янз бүрийн салбарт нэвтэрсээр байна.

Deutsche Bank, HSBC, KBC, Natixis, Rabobank, UniCredit зэрэг долоон банкнаас хил дамнанс худалдааны санхүүжилт авдаг жижиг, дунд компаниудад зориулсан шинэ блокчэйн системийг IBM компани байгуулж, үйлчилгээг нь харууцна.

Блокчэйн нь мөнгөнөөс авахуулаад эмнэлгийн онош хүртэлх бүхий л өгөгдлийг шифрлэн компани, хүмүүс, байгууллага хооронд дамжуулах боломж олгодог технологи. Хамаарах бүх талын мэдээллийг тэр дор нь шинэчилж явдаг өгөгдөлд засвар оруулах замаар луйвардах аргагүй. Аль XVI зууны Венецийн худалдаачдаас үүсэлтэй, үндсэндээ бичиг цаасны журамд захирагдсан, барааны төлбөрийг хэдэн долоо хоногоор хүлээлгэдэг худалдааны санхүүгийн хуучин тогтолцоог шинэ технологи түүх болгоно хэмээн дээрх банкууд тооцоолж байна.

“Блокчэйн нь ирээдүйд банкуудын үйл ажиллагаанд эргэлт гаргаж, худалдааны санхүүгийн

салбарт технологийн дэвшил авчирна” хэмээн KBC-ийн мэдээллийн технологийн ахлах ажилтан Руди Питерс тайлбарлав. KBC шинэ системийг Бельги дахь жижиг бизнес эрхлэгч үйлчлүүлэгчдэдээ туршилтын журмаар ашиглахаар төлөвлөж байна. Банкууд энэ оны эцэс гэхэд Европын жижиг, дунд бизнес эрхлэгчдийн худалдааг үүлэн суурьтай платформд тулгуурлан санхүүжүүлэхээр төлөвлөж байна.



BBM©

“Хэт цаасанд тулгуурласан, түвэгтэй, өртөг зардал ихтэй худалдааны санхүүжилтэд блокчэйн ашиглах нь чухам үр дүнтэй” хэмээн ноён Питерс өгүүлсэн юм. Блокчэйн технологийг “Жижиг, дунд бизнес эрхлэгч нарт нэвтрүүлэх шаардлага онцгой их. Учир нь жижиг, дунд бизнес эрхлэгч нарт худалдааны санхүүжилт удаан байдгаас зах зээлд эзлэх байр суурь хоцрогдмол” хэмээн тэрбээр нэмж тайлбарлав.

Банкууд шинээр үүсгэх платформоо хялбарыг нь бодож юун түрүүнд Европ тивийн авто тээврийн үндсэн шугамуудад нэвтрүүлж, хожим нь тив хоорондын далайн тээврийн шугамуудад өргөжүүлнэ.

Яваандаа бусад банк, далайн болон хуурай замын тээврийн компани, зээлийн байгууллагууд уг платформд нэгдэнэ хэмээн

тооцоолж байгаа. Блокчэйн платформ нь жижиг, дунд бизнес эрхлэгч нарт захиалгаа хянаж, бараа ачсан, хүргэсний дараах төлбөр автоматаар хийгддэг ухаалаг гэрээ ашиглах боломж бүрдүүлж өгнө.

Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг санхүүжүүлдэг уламжлалт аргатай харьцуулахад хавьгүй хямд төсөр шинэ платформд нэгдэх хүсэлтэй компаниудыг эхлээд банкууд шалгаж байж зөвшөөрөл олгох талаар ноён

Питерс тайлбарлав. Ханган нийлүүлэх ажиллагааг тоон технологид шилжүүлж, дэлхийг хэрээн тээврийн сүлжээг тогтмол найдвартай хянах зорилгоор контейнерийн тээвэр дэлхийд тэргүүлэгч Maersk компани энэ онд IBM-тэй хамтран ажиллах гэрээ байгууллаа.

Блокчэйн технологи ашигласан худалдааны санхүүжилтийн хамгийн анхны гүйлгээг Barclays банк, Израилийн Wave стартап компани өнгөрсөн есдүгээр сард хийсэн. Уг гүйлгээгээр Ирландын хамтран ажиллагч Opna компанийн 100 мянган ам.долларын бяслаг, цөцгийн тосны наймааны төлбөрийг Сейшелийн худалдааны компанид амжилттай шилжүүлсэн юм.

Тухайн үед 7-10 хоног шаарддаг байсан шилжүүлгийг дөрөв хүрэхгүй цагийн дотор гүйцэтгэжээ.



BBM©

Ши даргын эриний бэлгэдэл-Хятадын өндөр хурдны галт тэрэг

Люси Хорнби, Арчи Жан

Хятад орны тэргүүн Ши Жиньпин тус улсын өндөр хурдны дэгжин галт тэрэгнд “Үндэстний сэргэн мандал”-ын бэлгэдэл болсон шинэ нэр хайрлах замаар хуучин удирдагчийг удаан галт тэрэгтэй нь ардаа хоцроов.

Хятадад Ху Жинтаогийн засаглалын 2007 онд ашиглалтад орсон өндөр хурдны суман галт тэрэг нь тус улсын өөрчлөл шинэчлэлийн бэлгэ тэмдэг, нарийн технологи бүхий дэд бүтцэд шилжих хүсэл эрмэлзлийнх нь илрэл байлаа. Энэхүү цаг үеийн суман галт тэргийг бүгдийг нь “Хөсөхао” буюу “Яруу зохицол” гэж нэрлэсэн юм.

Уг загвараас илүү хурдан, илүү шинэ галт тэргийг “Фүшинхао” буюу “Сэргэн мандал” хэмээн нэрлэсэн нь ноён Шигийн “Хятад үндэстнийг сэргээн мандуулах” хөтөлбөрийн тусгал болж буй талаар тус улсын мэдээллийн хэрэгслүүд даваа гарагт мэдээлэв. “Яруу зохицол баяртай!” хэмээн Хятадын үндсэрхэг үзэлт Global Times сонин олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд пост байршуулжээ.

“Шинжлэх ухааны хөгжил”, “Яруу зохицолт нийгэм” гэх мэт

хавьгүй даруу уриа лоозонгоороо алдартай ноён Ху шүүмжлэгч нараа “зохицуулж” чадсан хүн хэмээх шог яриа Хятадад түгээмэл.

Ноён Хугийн 10 жилийн засаглалыг эдүгээ ч хүч нөлөө нь хэвээр байгаа өмнөх үеийн Эрх Зэмнн болоод өөрийгөө Хятадын Хятадын коммунист намын “цөм” хэмээн мэдэгдэх замаар эрх мэдлийг төвлөрүүлэгч ноён Ши нарын хоорондох засварын үе гэж тодорхойлдог болжээ.

Ноён Хугийн “Зохицолт” галт тэрэгнүүдийг эдүгээ арай удаан шугаманд ашиглаж буй талаар санхүүгийн Saixin сэтгүүл мэдээлэв. Өндөр хурдны суман галт тэрэг нь Хятад орны дотоодын тээврийн нүүр царайг өөрчилж, хэдэн өдрөөр үргэлжилдэг ядаргаат аяллыг хэдхэн цаг болгон богиносгож өгсөн. Гэхдээ Бээжин-Шанхайн ачаалалтай шугам, Хөх мөрний бэлчрийн зарим шугамыг тооцохгүй бол бараг бүх шугам алдагдалтай ажиллаж байгаа нь дотоодод шүүмжлэл хүлээх шалтгаан болов.

Дорнод Хятадын Вэньжоу хотын ойролцоо 2011 онд болсон аймшигт ослын дараа 300

тэрбум ам.долларын өртөгтэй өндөр хурдны зам тээврийн дэд бүтэцтэй холбоотой авлига, зардал хэмнэлтийн асуудал олны анхааралд өртлөө.

Бээжин өндөр хурдны галт тэрэгний технологийг хэд хэдэн улсад экспортлох хэлэлцээр байгуулсан. Гэвч эдгээр хэлэлцээр худалдааны тэмдэгтийн маргаанаас, ялангуяа Японы хөдөлгүүр үйлдвэрлэгч Kawasaki Heavy Industries-тэй хийсэн маргаанаас шалтгаалан ахиц муутай байгаа.

Шинэ суман галт тэрэг цагт 400 километр хурдлах чадалтай нь “Хятадын өндөр хурдны галт тэрэгний өрсөлдөх чадвар”-ыг сайжруулаа хэмээн тус улсын Төмөр замын яам тайлбарлав. “Сэргэн мандал” хятад патенттай тул экспортод гаргахад хялбар хэмээн тус яамны тайлбарт өгүүлжээ.

Анх дээд хурдыг нь цагт 350 километр байхаар тооцсон Хятадын өндөр хурдны галт тэрэгний дэд бүтэц нь замын болон аюулгүйн нөхцөл, тасалбарын үнийг боломжит түвшинд хадгалах хэрэгцээ шаардлагын улмаас дунджаар 200-250 км/цаг байгаа.



Эдийн засаг

УУЛ УУРХАЙ

Тавантолгойд буй төр, хувийн хэвшлийн ялгаа

Учир нь ашигтай ажиллах баталгаа “Оюутолгой” болж байгаа юм. Тавантолгойн ордын нийт нөөц нь 6.4 тэрбум тонн. Үүний 1.8 тонн нь коксжих нүүрс. Үлдсэн нь эрчим хүчнийх. Тавантолгойн ордын эрчим хүчний нүүрсийг эдийн засгийн эргэлтэд оруулах нь төслийн шатанд яваа цахилгаан станцаас ихээхэн шалтгаалахаар байна. Ингэснээр Тавантолгойн өгөөж илүү нэмэгдэх юм.

“Оюутолгой” цахилгаан эрчим хүчээ энэ оноос дотоодоос хангах гэрээ байгуулсан. Гэтэл манай улс хөрөнгө оруулагчидтай байгуулсан гэрээнд тусгасан “амлалт”-аа өөрсдөө биелүүлж чадсангүй. Ийм нөхцөлд “Оюутолгой”-г Монголоос эрчим хүчээ ав гэж шахах эрх бидэнд байхгүй. Хэдий “Оюутолгой”-н гүний уурхайн хоёр дахь шат хэрэгжиж эхэлсэн ч манай улс өөрсдийн эрчим хүчний хэрэгцээгээ хэрхэн яаж хангах талаар толгойгоо гашилгаж суугаа. Тавантолгойн цахилгаан станцын төслийн ажил өнгөрсөн хугацаанд урагшилсан боловч ухарсан нь их. Төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчийг өнгөрсөн онд тодруулсан. Харамсалтай нь яриа, хэлэл удааширч, зогсонги байдалд ороод байна.

Тавантолгойн ордтой энэ сарын 21-нд танилцсан уул уурхайн салбарынхан уг төслийн явцыг хамгийн их сонирхож байв. Тэдний анхаарлыг татаж буй цахилгаан станцын барилга угсралтын ажил 20 сар үргэлжилн гэж урьдчилсан байдлаар тооцжээ. Энэ үед ойролцоогоор 2500 хүний ажлын байр шинээр бий болно гэж төслийн нэгжээс өмнө нь мэдээлж байсан. Энэхүү төслийн нийт санхүүжилт нэг тэрбум ам.доллар. Үүний 30 хувь нь хөрөнгө оруулагчийн



С.Батсайхан / ЗГМФ

шууд хөрөнгө оруулалт байх бол үлдсэн 70 хувь олон улсын банк, санхүүгийн байгууллагаас татсан зээлийн эх үүсвэр байх юм.

» «Оюутолгой» цахилгаан эрчим хүчээ энэ оноос дотоодоос хангах гэрээ байгуулсан.

» Манай улсын уул уурхайн салбарт төрийн оролцоо илт давамгайлж буй.

» Цахилгаан станцын дөрвөн хүн тутмын гурав нь орон нутгийнх.

“Эрдэнэс Тавантолгой”-д шаардлагатай цахилгаан эрчим хүчийг хувийн хэвшил угтаа нийлүүлж байна. Төр, хувийн

хэвшлийн энэ хоёр компани хаяа залган оршдог ч тэдний хооронд зааг, ялгаа их юм. Нэг нь олборлосон бүтээгдэхүүнээ шууд экспортод гаргаж байгаа бол нөгөө нь угааж, баяжуулж, нэмүү өртөг шингээж байна. Тэрчлэн эрчим хүч гарган авч үүнийгээ борлуулж байна.

Манай улсын уул уурхайн салбарт төрийн оролцоо илт давамгайлж буй. Ялангуяа нүүрсний салбарт төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” томоохон байр суурь эзэлж байгаа. Ийм атлаа хувийн хэвшлийн компаниудтай харьцуулахад чамлалтай санагдах зүйл цөөнгүй. Хэрэв Ухаа худагийн уурхайг түшиглэн хувийн хэвшил 18 мегаваттын хүчин чадалтай цахилгаан станц бариагүй бол Тавантолгойн ордод үйл ажиллагаа явуулж буй компаниуд эрчим хүчний хувьд хүндрэлд орох байсныг

үгүйсгэх аргагүй юм.

Хувийн хэвшлийн босгосон цахилгаан станц төвийн эрчим хүчнээ аллагдсан Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг тог цахилгаанаар найдвартай хангаж байна. Илүүдэл цахилгаанаа төвийн бүсийн эрчим хүчний нэгдсэн системд нийлүүлж байгаа аж. Үйл ажиллагаа явуулахад зургаа дахь жилийнхээ нүүрийг үзэж буй хувийн хэвшил компанийн 18 мегаваттын цахилгаан станц эхэнд дурдсан Тавантолгойн цахилгаан станцтай харьцуулахад хүчин чадлын хувьд тэнгэр, газар шиг ялгаатай. Хэдий ийм боловч орон нутгийн хэрэгцээг хангаж, эрчим хүчний найдвартай эх үүсвэр нь болж байна. 60 мянган хүн амтай зургаан аймгийн цахилгааны хэрэгцээг бүрэн хүчин чадалтай энэхүү станцын гол хэрэглэгч нь баяжуулах үйлдвэр гэнэ.

Цахилгаан станцыг барихад 80 орчим дотоодын компани, 40 гаруй гадаадын компанитай хамтран ажилласан болохыг тус станцын үйл ажиллагаа хариуцсан захирал хэлж байсан юм. Барилга угсралтын үед 500 хүн ажиллаж байсан бол өдгөө 200 орчим хүнийг байнгын ажлын байраар хангаж байгаа аж. Цахилгаан станцын дөрвөн хүн тутмын гурав нь орон нутгийнх. Тэр дундаа нийт ажилтны 20 гаруй хувь нь Цогтцэций сумын уугуул иргэд байдаг гэв. Төр цахилгаан станц барих гэж олон дуншиж байхад хувийн хэвшил аль хэдийнэ бүтээн байгуулахад үр шимийг нь хүртэж байна. Орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд төрийн оролцоогүй компани хамгийн их үүрэг гүйцэтгэж бас ачааны хүндийг үүрч байгааг уншигч та эндээс анзаарсан болов уу. [ЗГМ]

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

"Rio Tinto" компани шинэ сонголтын өмнө ирлээ



Н.Алтан
Шинжээч

Хэцүүхэн сонголттой тулгараад байсан "Rio Tinto" компани эцсийн шийдвэрээ гаргаж, Австрали дахь "Coal & Allied" нэгжээ БНХАУ-ын "Yancoal" компанид худалдахаар боллоо. "Yancoal"-ийн удирдлагууд "Glencore"-ийн саналын эсрэг үнийн дүнгээ 2.69 тэрбум ам.доллар болгон өсгөсөн байна. Үүнд анх санал болгосон 2.45 тэрбум ам.долларыг бэлнээр төлөхөөс гадна нөөц ашигласны төлбөрт олгох 240 сая ам.доллар багтжээ. Үүнээс өмнө "Glencore" компани саналаа дахин өсгөж, 2.68 тэрбум ам.долларт хүргэснээр "Rio Tinto" сонголттой эргэн харахаас аргагүй байдал үүсээд байсан юм. Хэлцэл энэ оны гуравдугаар улиралд багтан эцэслэгдэх хүлээлттэй байна. Ийнхүү салбар нэгжээ "Yancoal"-д худалдах болсон нь хөрөнгө оруулагчдад хамгийн ашигтай гэж үзэж байгаагаа "Rio Tinto" мэдэгдлээ.

Түүнээс гадна хууль эрх зүйн таласаа зөвшөөрөл авах боломж, санхүүжилтийн тодорхой байдал зэрэг нь нөлөөлсөн гэдгийг тус компанийн удирдлагууд

онцолж байгаа юм. "Rio Tinto"-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар "Yancoal"-ийн саналыг хэлэлцэн эцэслэх товтой байна. Олон улсын хэмжээнд нүүрснээс татгалзаж, сэргээгдэх эрчим хүчний чиглэл эрчээ авч байгаа энэ үед "Glencore" нүүрсний салбарт анхаарал хандуулж байгаа нь салбарын шинжээчдийн анхаарлыг ийнхүү татаж байна.

Учир нь "Rio Tinto", "BHP Billiton" зэрэг уул уурхайн томоохон компаниуд нүүрснээс татгалзаж байгаа юм. Харин "Glencore" хөгжиж буй орнууд, ялангуяа Азийн дэд бүтцийн урт хугацааны хөгжилд нүүрсний салбар томоохон үүрэг гүйцэтгэнэ гэж мэдэгдсэн байна. Мөн ирэх 10 жилд дэлхийн эрчим хүчний салбарт нүүрс болон шатамхай түлшний орон зай хэвээр байна гэж "Glencore" компанийн гүйцэтгэх захирал мэдэгджээ. Ийнхүү "Rio Tinto"-ийн уурхайнуудыг худалдан авах нь тус компанийн хувьд стратегийн ач холбогдолтой асуудал гэж үзэж байна. Иймээс хэрэв саналыг "Rio Tinto" хүлээн авбал "Glencore" компани 1.5 тэрбум ам.доллар босгох үйл ажиллагаа эхлүүлэхээ ч мэдэгджээ.

ДЭЛХИЙ

"Spicejet"-ийн хувьцааны ханш 124 хувиар өсөв

Н.Илч
Шинжээч

Энэтхэгийн агаарын тээврийн "Spicejet" компанийн хувьцааны ханш салбартаа хамгийн сайн үзүүлэлттэй тооцогдож байна. Тус компанийн хувьцааны ханш он гарсаар 124 хувиар өссөн

төдийгүй 2014 оноос хойших өсөлт 800 хувиар хэмжигдэж байгаа юм. Хоёр жил хагасын өмнө л гэхэд "Spicejet" түлшний төлбөрт 2.2 сая ам.доллар төлөх өрөнд унаад байсан аж. Хэдий ийм боловч тус компанийн үүсгэн байгуулагч капиталын урсгалыг нэмэгдүүлж, ашиггүй нислэгүүдийг цуцалснаар үйл

ажиллагаа нь эрс сайжирчээ.

Мөн энэ хугацаанд газрын тосны ханш доод хэмжээнд байсан нь эерэг нөлөө үзүүлсэн байна.

Ийнхүү газрын тосны ханш уналттай хэвээр байвал "Spicejet"-ийн хувьцааны ханш өсөлттэй байх боломжтойг шинжээчид онцолжээ.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 06 сарын 28- ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр:

Зорчигчийн үйлчилгээнд самар нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер

Тендер шалгаруулалтын дугаар: **28/2017-М**

МИАТ ХК эрх бүхий тендер оролцогчдоос “Зорчигчийн үйлчилгээнд самар нийлүүлэх” битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50000** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар МИАТ ХК –ийн төв байрны кассанд бэлнээр тушааж, **103** тоот өрөөнөөс худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ сүүлийн 1 жилд: **100 сая төгрөгнөөс багагүй,**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **140 сая төгрөгнөөс багагүй,**

Санхүүгийн аудитаар баталгаажсан тайлан ирүүлэх жил: **2015, 2016 он**

Тендерийн хамт 4,056,000 төгрөгийн тендерийн баталгааг ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 07 сарын 24-ний өдрийн 09 цаг 00 минут –аас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 07 сарын 24- ний өдрийн 09 цаг 30 минутанд** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлж болно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

МИАТ ХК

Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа дахь, МИАТ ХК –ийн төв байр, Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот өрөө

Утас: 70049860, Факс: 70049919

ЗГМ ТОВЧХОН

» ИПОТЕК

2.6 хувь
Хугацаа хэтэрсэн ипотекийн зээлийн 2.6 хувийг гадаад валютын зээл бүрдүүлж байна.

» СТАТИСТИК

17.3 хувь
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 17.3 хувь нь баруун бүсэд байна.

» УУЛ УУРХАЙ

40 төсөл
Улсын хэмжээнд геологийн судалгааны дөрвөн чиглэлээр 40 төсөл хэрэгжиж байна.

» ӨРСӨЛДӨХ ЧАДВАР

“Аймгуудын өрсөлдөх чадварын 2016 оны тайлан”-д Дорнод 21 аймгаас наймдугаар байрт эрэмбэлэгджээ. Энэхүү тайланг Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс тав дахь жилдээ бэлтгэн гаргасан юм. Аймгуудын өрсөлдөх чадварыг 180 үзүүлэлтээр хэмждэг.

» АЖ ҮЙЛДВЭР

90 үйлдвэр
Улсын хэмжээнд савласан усны нийт 90 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.

» БАНК, САНХҮҮ

4.4 хувь
Банкны салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 4.4 хувь буюу 660 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэж байна.

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Иргэдийн хоёр хүрэхгүй хувь нь хөрөнгийн зах зээлд оролцож байна гэж Санхүүгийн зохицуулах хорооноос мэдээллээ.

» ЗЭЭЛ

21.4 хувь
Өрхийн зээл дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа манай улсад 21.4 хувь байгаа бол дунджаас дээш орлоготой орнуудад энэ тоо 21.9 хувьтай байна.

» ЭКОЛОГИ

86.2 хувь
“Оюутолгой” компанийн ус дахин ашиглалтын жилийн дундаж түвшин 86.2 хувьтай байна.

» ТӨСӨВ

59 тэрбум төгрөг
“Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр жилд дунджаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хэлбэрээр 33-59 тэрбум төгрөг улсын төсөвт оруулах төсөөллийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас гаргажээ.

ВАЛЮТЫН ХАНШ

| | |
|------------|---------|
| АНУ доллар | 2355.51 |
| Евро | 2629.46 |
| Япон иен | 21.22 |
| ОХУ рубль | 39.23 |
| БНХАУ юань | 344.84 |
| БНСУ вон | 2.06 |

Эдийн засаг

САНХҮҮ Даатгалын компаниуд 37.5 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлжээ

Н.Алтан
Шинжээч

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниуд энэ оны эхний улиралд 37.5 тэрбум төгрөгийн нийт хураамжийн

орлого төвлөрүүлжээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37.7 хувиар өссөн үзүүлэлт болж байна. Даатгалын хураамжийн нийт орлогын 75.3 хувь нь даатгалын хэлбэрийн хураамжийн орлогоос бүрдэж байгаагийн 36.3 хувийг хөрөнгийн даатгал, 16.5 хувийг


Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал тус тус эзэлж байгааг Санхүүгийн зохицуулах хорооноос мэдээллээ. Энэ оны эхний улиралд 15.7 даатгуулагчдад 8.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Нөхөн төлбөрийг даатгалын хэлбэрээр

нь авч үзвэл Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаар 4.4 тэрбум төгрөгийн, авто тээврийн хэрэгслийн даатгалаар 2.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон нь хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөр болжээ. Хэдийгээр даатгалын хураамжийн орлого

жил ирэх тусам нэмэгдэж байгаа ч даатгалын нэвтрэлт, нягтрал муу байгааг Санхүүгийн зохицуулах хороо мэдэгдэж байна. Иймээс иргэдийн санхүүгийн боловсролыг дэмжих, даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх ажил чухал байгааг холбогдох албаныхан ийнхүү

онцолж байна. Үүнээс гадна хувийн Тэтгэврийн даатгалын тогтолцоог бүрдүүлэх ажлын хэсэг ажиллаж байгаа төдийгүй хуулийн төсөл боловсруулан танилцуулах шатандаа байгааг Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газраас мэдээллээ.


“Ган хийц”-ийн хувьцаа 8.63 хувиар буурав



MSE All индекс


Монголын хөрөнгийн бирж мягмар гарагийн үнэт цаасны арилжаагаар нэг, хоёр болон гуравдугаар ангилалд бүртгэлтэй 14 хувьцаат компанийн нийт 21,176 сая ширхэг хувьцаа 10.51 сая төгрөгөөр арилжжээ. Ханшийн өөрчлөлтийн хувьд 10 компанийн хувьцааны ханшид өөрчлөлт орсон байна. Үүнээс “Хөвсгөл алтан дуулга”

компанийн хувьцаа хамгийн өндөр буюу 14.99 хувиар өссөн бол “Ган хийц”-ийнх 8.63 хувиар буурав. Зах зээл дээр хөрөнгө оруулагчдын хооронд нийт 38 удаагийн хэлцэл хийгдсэн байна. Салбарын хувьд авч үзвэл хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хувьцаа үнийн дүнгийн 53.9 хувийг бүрдүүлжээ. [ЗГМ]



МЭДЭЭЛЛИЙН ЧАНАР
АМЖИЛТЫН ҮНДЭС

Microsoft Dynamics NAV ERP системийг Монголд



INTER SOLUTIONS MANAGEMENT LLC
УТАС: +976 76009293
support@ism.mn

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

| НЭР | СИМБОЛ | БИРЖ | ВАЛЮТ | ХАНШ | ӨӨРЧЛӨЛТ % | ОГНОО |
|--------------------------|--------|------|-------|-------|------------|-----------|
| RIO TINTO | RIO | ASX | AUD | 59.85 | ▲ 0.47% | 6/27/2017 |
| WOLF PETROLEUM | WOF | ASX | AUD | 0.026 | ▼ -3.70% | 6/27/2017 |
| PETRO MATAD | MATD | LON | GBX | 9.875 | ▲ 1.30% | 6/27/2017 |
| ASPIRE MINING | AKM | ASX | AUD | 0.018 | ▼ -5.26% | 6/27/2017 |
| GUILDFORD COAL | GUF | ASX | AUD | 0.013 | ▼ -7.69% | 6/27/2017 |
| PROPHECY DEVELOPMENT | PCY | TSX | CAD | 3.12 | ▼ -6.02% | 6/27/2017 |
| TURQUOISE HILL RESOURCES | TRQ | TSX | CAD | 3.55 | ▲ 1.72% | 6/27/2017 |
| SOUTHGObI RESOURCES | SGQ | TSX | CAD | 0.33 | ▲ 13.79% | 6/27/2017 |
| XANADU MINES | XAM | ASX | AUD | 0.175 | ▼ -12.50% | 6/27/2017 |
| ENTREE GOLD | ETG | TSX | CAD | 0.475 | ▼ 2.15% | 6/27/2017 |

ТҮҮХИЙ ЭД

| НЭР | СИМБОЛ | НЭГЖ | ХАНШ (\$) | ӨӨРЧЛӨЛТ % | ОГНОО |
|--------------------|--------|---------|-----------|------------|-----------|
| АЛТНЫ СПОТ | XAU | унци | 1251.13 | ▲ 0.51% | 6/27/2017 |
| ЦАГААН АЛТ | PLA | унци | 922 | ▲ 0.41% | 6/27/2017 |
| МӨНГӨ | SIA | унци | 16.68 | ▲ 0.29% | 6/27/2017 |
| ЗЭС (COMEX) | HGA | фунт | 264.05 | ▲ 0.08% | 6/27/2017 |
| ТӨМРИЙН ХҮДЭР | TIOA | тонн | 55.5 | ▲ 1.37% | 6/27/2017 |
| WTI ТОС | CLA | баррель | 43.83 | ▲ 1.04% | 6/27/2017 |
| БРЕНТ | COA | баррель | 46.41 | ▲ 1.27% | 6/27/2017 |
| БЕНЗИН | XBA | баррель | 145.71 | ▲ 1.28% | 6/27/2017 |
| БАЙГАЛИЙН ХИЙ | NGA | Mmbtu | 3.045 | ▲ 0.59% | 6/27/2017 |
| НҮҮРС (NYMEX) | QZA | тонн | 336.55 | ▲ 0.21% | 6/27/2017 |
| НҮҮРС (NEW CASTLE) | XWA | тонн | 77.85 | ▼ -1.02% | 6/27/2017 |
| ЭЛСЭН ЧИХЭР | SBA | фунт | 12.94 | ▲ 0.70% | 6/27/2017 |
| БУДАА | RRA | центнер | 11.54 | ▲ 0.65% | 6/27/2017 |
| БУУДАЙ | WA | бушель | 469 | ▲ 0.75% | 6/27/2017 |
| КАКАО | CCA | тонн | 1875 | ▲ 1.63% | 6/27/2017 |
| КОФЕ | KCA | фунт | 124.95 | ▲ 0.36% | 6/27/2017 |

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

| НЭР | СИМБОЛ | ХАНШ (нэгж) | ӨӨРЧЛӨЛТ % | ОГНОО |
|-------------------------|--------|-------------|------------|-----------|
| АПУ ХК | APU | 290.72 | ▼ -0.56% | 6/27/2017 |
| ГОВЬ ХК | GOV | 13400 | ▼ -0.74% | 6/27/2017 |
| СҮҮ ХК | SUU | 127.19 | ▼ -1.34% | 6/27/2017 |
| ГАН ХИЙЦ ХК | GHC | 14620 | ▼ -8.63% | 6/27/2017 |
| ХАСУ-МАНДАЛ ХК | HSR | 3600 | ▲ 0% | 6/27/2017 |
| МАТЕРИАЛ ИМПЕКС ХК | MIE | 8000 | ▲ 2.56% | 6/27/2017 |
| МЕРЕКС ХК | MRX | 62.1 | ▼ -0.67% | 6/27/2017 |
| РЕМИКОН ХК | RMC | 46.14 | ▼ -7.05% | 6/27/2017 |
| ТАВАНТОЛГОЙ ХК | TTL | 4805 | ▲ 1.03% | 6/27/2017 |
| ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХК | ADU | 2324 | ▲ 14.99% | 6/27/2017 |
| СТАНДАРТ НООС ХК | ALI | 449 | ▲ 0% | 6/27/2017 |
| ДАРХАН ХӨВӨН ХК | DAH | 18000 | ▲ 0% | 6/27/2017 |
| МОН-ИТ БУЛИГААР ХК | MBG | 8500 | ▲ 0% | 6/27/2017 |
| МАНДАЛ ГОВЬ ИМПЕКС ХК | MNG | 135 | ▲ 1.20% | 6/27/2017 |

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

| НЭР | СИМБОЛ | ХАНШ (нэгж) | ӨӨРЧЛӨЛТ | ӨӨРЧЛӨЛТ % | ОГНОО |
|------------------------------|--------|-------------|----------|------------|-----------|
| NASDAQ COMPOSITE | COMP | 6247.148 | -18.1 | ▼ -0.29% | 6/27/2017 |
| DAX INDEX | DAX | 12706.64 | -64.19 | ▼ -0.5% | 6/27/2017 |
| TORONTO STOCK EXCHANGE | SPTSX | 15316.02 | -3.54 | ▼ -0.02% | 6/27/2017 |
| S&P/ASX 200 | AS51 | 5714.194 | -5.97 | ▼ -0.1% | 6/27/2017 |
| S&P 500 | INX | 2439.07 | +0.77 | ▲ +0.03% | 6/27/2017 |
| SHANGHAI COMPOSITE | SHCOMP | 3191.197 | +5.75 | ▲ +0.18% | 6/27/2017 |
| DOW JONES INDUSTRIAL AVERAGE | INDU | 21409.55 | +14.79 | ▲ +0.07% | 6/27/2017 |
| TOP 20 | MSETOP | 12658.81 | -29.38 | ▼ -0.23% | 6/27/2017 |
| FTSE 100 | UKX | 7435.25 | -11.55 | ▼ -0.16% | 6/27/2017 |
| HANG SENG | HSI | 25839.99 | -31.9 | ▼ -0.12% | 6/27/2017 |
| NIKKEI 225 | NIKY | 20225.09 | +71.74 | ▲ +0.36% | 6/27/2017 |



ДЭЛХИЙГ ӨӨРЧЛӨХ
ЗАРДАЛ

ХОРТ ХАВДРЫГ ЭМЧЛЭХЭД

\$ 810 ТЭРБҮМ

ЖИЛ БҮР

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
|  |  |  |  |  |  |  |  |
| ХАНДИВ ЦУГЛУУЛАХ | ГЭРЭЭР ЭМЧЛҮҮЛЭГСЭД | ЭМНЭЛГИЙН ЗАРДАЛ | ЖОРООР ОЛГОХ ЭМ | УДИРДЛАГЫН ЗАРДАЛ | МЭДЛЭГ ОЛГОХ | СЭТГЭЛЗҮЙН ТУСЛАМЖ | СУДАЛГАА |
| \$3.3 ТЭРБҮМ | \$407.4 ТЭРБҮМ | \$285.2 ТЭРБҮМ | \$89.6 ТЭРБҮМ | \$1.3 ТЭРБҮМ | \$2.8 ТЭРБҮМ | \$1.9 ТЭРБҮМ | \$18.5 ТЭРБҮМ |

ДЭЛХИЙД ИЛҮҮ ОЛОН ТЭРБҮМТАН ХЭРЭГТЭЙ

